

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ ХАВРЫН  
ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 6 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДӨР  
/МЯГМАР ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-12
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	13-112
	1.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл <i>/Засгийн газар 2021.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	13-28
	2.Кино урлагийг дэмжих тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд <i>/Засгийн газар 2019.04.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	28-37
	3.“Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл <i>/анхны хэлэлцүүлэг/</i>	37-38
	4.Монгол Улсын шүүхийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл <i>/Засгийн газар 2021.06.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	38-41
	5.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд <i>/Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	42-85
	6.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан болон “Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл <i>/Засгийн газар 2021.06.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, нэг дэх хэлэлцүүлэг/</i>	85-112

## ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

***Тав.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, мөн яамны Бодлого төлөвлөлтийн газрын дарга Ж.Ганбаатар, мөн газрын шинжээч Ж.Нарантуяа, Сургуулийн өмнөх боловсролын газрын дарга Ж.Мягмар, Бага, дунд боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Хуулийн хэлтсийн дарга Б.Мөнгөнбагана, мөн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Баярмаа, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэд захирал, доктор Т.Намнан, боловсрол судлаач, доктор П.Оюунаа нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Бад.Баярмаа, Р.Болормаа, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Дамдинням нар “Их хуралдай” танхимаас тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг, Н.Наранбаатар, О.Цогтгэрэл, Б.Жаргалмаа, Г.Тэмүүлэн, Н.Учрал, Н.Ганибал, Т.Доржханд, Н.Алтанхуяг, С.Чинзориг, Ц.Мөнхцэцэг, Б.Баярсайхан нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол,

шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Батбаатар, мөн яамны Бага, дунд боловсролын газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга С.Должин, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэд захирал, доктор Т.Намнан, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Дамдинням нар “Их хуралдай” танхимаас тус тус хариулж, тайлбар хийв.

Төслийн үзэл баримтлалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг, Ц.Мөнхцэцэг, Л.Энх-Амгалан, Ч.Ундрам, Н.Алтанхуяг, Б.Баярсайхан нар үг хэлэв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.12-т заасны дагуу санал хураалтыг MyParliament программыг ашиглан цахим хэлбэрээр явуулав.*

**Г.Занданшатар:** Байнгын хорооны саналаар Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай, Боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулиудын болон “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	45
Татгалзсан:	20

Бүгд: 65

69.2 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлэв.

*Уг асуудлыг 20 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.*

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.**

Хууль санаачлагчийн илтгэлийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Энх-Амгалан сайдыг индэрт урьж байна.

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, өнөөдөр Монгол Улс оюуны чадавхаараа дэлхийд эхний 12 орны тоонд орж байгаа хэдий ч хүний хөгжлийн индексээр 189 орноос 92-т, боловсролын индексээр 189 орноос 103-т, өрсөлдөх чадварын индексээр 64 орноос 60-д, оюуны чадавхаа хэрэглэх үр чадвараар 49-т, мэдлэг чадвараа хөгжүүлэх үзүүлэлтээр 59-т орж байна.

2018 онд хийгдсэн нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны үр дүнгээс харахад 7-14 насны хүүхдийн сурч чадах үндсэн чадвар болсон, унших чадвар 61,5 хувь, энгийн аргын тоо бодох чадвар 51,5 хувь байгаа зэрэг нь боловсролын чанар, үр дүнд чиглэсэн эрх зүйн шинэчлэл хийх практик хэрэглээг илтгэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор Алсын хараа 2050 Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлагдаж, хүний хөгжил төвтэй хөгжлийн бодлого хэрэгжиж эхэлсэн. Уг бодлогын үргэлжлэл болох Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл болон 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршийн суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх зорилтыг тус тус дэвшүүлсэн билээ.

Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангахад тулгуур болох боловсролын салбарын эрх зүйн зохицуулалт, түүнийг хэрэгжүүлж буй хууль тогтоомж хангалтгүй байгаа тул энэхүү шинэчилсэн найруулгыг боловсруулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

Түүнчлэн боловсролын хөгжлийн олон улсын чиг хандлага, өөрийн улсын хөгжлийн бодлого төлөвлөлттэй уялдуулан боловсролын зорилгыг шинэчлэх, хувьсан өөрчлөгдөж байгаа дэлхий ертөнцөд шинээр болж буй өргөн боломж, түүний дотор технологийн дэвшлийг ашиглан боловсролыг эзэмших шинэ арга, хэлбэрийг уян хатан, эрчимтэй болгохын хамт сургалтын хөтөлбөрийг залгамж холбоотой, тогтвортой байх нөхцөлийг хангах, үнэлгээний тогтолцоог сайжруулах, багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг чанаржуулах, сургуулийн хэв шинж, бүтэц, байршлыг оновчтой болгох, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна.

Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын сурлагын ахиц, амжилтын талаарх өөрийн болон хөндлөнгийн үнэлгээний дүн өөр хоорондоо зөрүүтэй, хот хөдөөгийн сургалтын чанар харилцан адилгүй байгаа нь сурлагын ахиц, амжилтыг тодорхой давтамжтайгаар, хөндлөнгөөс үнэлэх үнэлгээний тогтолцоог бүх шатны сургуульд нэвтрүүлэх шаардлагатайг харуулж байна.

Багшийн мэргэжил, ажиллах нөхцөл, хөдөлмөрийн үнэлэмжийг эрс сайжруулах цогц механизм бүрдүүлэх замаар мэргэжлийн нэр хүнд, нийгмийн үнэлгээг дээшлүүлж, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үнэлгээ, цалин хөлсийг хөдөлмөрийн бүтээмж, ажлын гүйцэтгэл, үр дүнтэй уялдуулснаар нийгэм дэх нэр хүнд, үнэлэмжийг нэмэгдүүлэх, багш бэлтгэх үндэсний тогтолцоог бий болгох, чадваржуулах, сургалтын чанар, үнэлгээ, үр дүнг сайжруулах, чанартай багш бэлтгэх хэрэгцээ, шаардлага Монгол Улсад байна.

Боловсролын санхүүжилтийн өнөөгийн тогтолцоо нь хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарсан, боловсролын чанар, гүйцэтгэл үр дүнтэй, уялдаа холбоогүй, нэг хүүхдийг сургаж буй бодит өртөг, зардал ялгаа ихтэй сургалтын хөтөлбөр болон боловсролын стандартыг хангах, сургалтын байгууллага төсөв санхүүжилтээ үр ашигтай, захиран зарцуулах идэвх санаачилгыг урамшуулдаггүй зэрэг сул талтай байна.

Ерөнхий боловсролын сургуулийг хагас бие даасан тогтолцоонд шилжүүлэх, нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлын санхүүжилтийн аргачлалыг шинэчлэх, сургуулийн бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой хувилбарыг тогтоох, сургалтын чанарт суурилсан багшийн цалин, урамшууллыг олгох нөхцөлтэйгөөр жил бүр төсөв, санхүүгийн шударга, зохистой дэмжлэг үзүүлэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлнэ.

Боловсролын зээлийн санг Засгийн газраас тогтоосон тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн хөтөлбөрт элсэгчдэд их, дээд сургууль, коллежийн тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр ахисан шатны суралцагчдын сурлагын амжилт, судалгааны ажлын чанартай уялдуулан шаардлага хангасан тохиолдолд сургалтын тэтгэлэг, тусламж, зээл олгох төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, оюутны болон багшийн хөгжлийг дэмжих хэлбэрээр өөрчлөн зохион байгуулна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын статус, хэв шинж, бүтэц, засаглалын тогтолцоо, хөтөлбөрт тавигдах шаардлага, санхүүжилтийн хэлбэрийг үр ашигтай, оновчтой болгох хэрэгцээ шаардлага байна.

Шинжлэх ухаан, дээд боловсролын уялдааг өргөжүүлэх, судалгаа, судалгааны их сургуулийг шинжлэх ухааны судалгааны их сургууль болон шинжлэх ухааныг бэхжүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын статус, хэв шинж бүтэц сайжирч, удирдах зөвлөлд ажил олгогч, мэргэжлийн холбоод, олон нийтийн байгууллагын төлөөлөл, бизнес, хөрөнгө оруулагчдын төлөөллийг оруулснаар сургалт, судалгаа, үйлдвэрлэл, академик эрх чөлөө, боловсролын чанарын баталгааны тогтолцоо сайжрах болно. Их дээд сургуулийн засаглал, удирдлагын хараат бус, бие даасан байдал хангагдаж, ахисан түвшний сургалт, судалгаа, олон улсын жишигт хүрэх нөхцөл бүрдэнэ.

Бүх шатны боловсролын чанарын баталгаажуулалт нь байгууллагын сургалт, судалгааны үйл ажиллагааны гүйцэтгэл болон чанарын удирдлагыг сайжруулахад чиглэж, нээлттэй, бүх талын оролцогч талыг хамарсан, тасралтгүй үйл ажиллагаа бүхий тогтолцоог бүрдүүлнэ.

Боловсролын магадлан итгэмжлэх үйл ажиллагааг олон улсын жишигт нийцүүлж, төрөөс хараат бус, мэргэжлийн, олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц болох зохицуулалтууд хийгдэнэ.

Боловсролын сургалтын байгууллагын засаглалыг бие даалгах, удирдах албан тушаалд томилогдох хүмүүст тавих шалгуур, мэргэшсэн чадахуйн зарчмыг баримталж эрх үүргийг нарийвчлан тусгасан болно.

Боловсролын салбарын удирдах ажилтны тогтолцоо нь шатлан дэвшсэн, мэргэшсэн тогтолцоотой болсон байна. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяа байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн боловсролын газар, хэлтсийн ажлын чиг үүрэг, зохион байгуулалтын хэлбэрийг оновчтой болгон өөрчилнө.

Монгол Улсын дунд хугацааны бодлогын бичиг баримт болон и-монгол цахим засаглал үндэсний хөтөлбөрийн хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны технологийг боловсролд ашиглах, алсын харааг тодорхойлж, боловсролын салбарын бодлого, үндэсний мэдээлэл харилцааны холбооны технологийн зорилтуудтай нийцүүлэх шаардлагатай байна. Боловсролын салбарын удирдлагын мэдээллийн системийг бүрэн хөгжүүлж, салбарын бодит мэдээлэлд тулгуурлан хичээл, сургалтын үйл ажиллагаатай холбоотой төлөвлөлт хийх шийдвэр гаргах, сургууль, цэцэрлэгт улсын төсвөөс олгодог хувьсах зардал, хоолны мөнгө зэрэг зардлын гүйцэтгэлийг хянах боломжийг бүрдүүлнэ. Боловсролын цахим мэдээллийн нэгдсэн сан, төрийн болон иргэдийн мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтыг тусгана. Боловсрол эзэмших танхимын, танхимын бус хосолсон сургалтыг үнэлэх, дүйцүүлэх, баталгаажуулах асуудлыг тусгана.

Насан туршийн суралцахуйн эрх зүйн орчныг бүрдүүлж, салбар дундын мэргэжлийн үндэсний шаталсан бүтцийг боловсролын түвшин бүрд хэрэглэж хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах үйл ажиллагаа хэрэгжих нөхцөл бүрдэнэ.

Боловсролын салбар эрх зүйн шинэчлэл хийгдсэнээр ядуурлын бүх төрлийг эцэс болгох, орлогын тэгш бус байдлыг багасгаж, хүн амын 80 хувь нь дундаж болон чинээлэг давхаргын ангилалд багтах, суурь болон мэргэжлийн боловсролд хамрагдалтын түвшнийг 100 хувьд хүргэх, насан туршийн суралцахуйн тогтолцоог шинэчлэх, хүний хөгжлийн үзүүлэлтээр улс орнуудын жагсаалтын эхний 70 орны нэг болох, хөгжлийн бодлогоо бүх түвшинд хэрэгжүүлэх чадвартай, авлигаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн тогтвортой засаглал төлөвших үндсийг бүрдүүлэх суурь болно.

Хүний хөгжлийн үндсэн хэмжүүр нь улс орны болон хувь хүний хөгжил байх гол зарчмыг үндэс болгон хуулийн төслийг боловсруулсан ба иргэн бүр эрүүл байж, боловсрол эзэмшиж, амьжиргаандаа хүрэлцэхүйц орлоготой боломжийг бүрдүүлж, ядуурал, ажилгүйдлийг бууруулж, дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, хүн амын амьжиргааны түвшнийг дээшлүүлэх, мэдлэгт суурилсан нийгэм, ур чадвартай, зөв Монгол хүнийг төлөвшүүлэхэд энэ хуулийн зорилго оршино.

Эрхэм Улсын Их Хурлын гишүүд ээ, Боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын үзэл баримтлалыг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхийг дэмжиж өгөхийг хүсье.

**Г.Занданшатар:** Төслийн талаарх Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Гонгорын Дамдинням танилцуулна.

**Г.Дамдинням:** Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Боловсрол соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо 2021 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанд хуулийн төслийн үзэл баримтлалын талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан танилцуулга хийсэн бөгөөд тус Байнгын хорооны гишүүд төсөлтэй холбоотой асуулт асууж, холбогдох хариултыг авсан болно.

Хуулийн төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам ашиглалтын суурь зардал болон сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг хэрхэн олгох, хувийн хэвшлийн сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн сурагчид төрөөс хувьсах зардлыг олгох эсэх, их, дээд сургуулийн багш нарын хувьд нийгмийн баталгаа, цалин хөлсний ялгамжтай байдлыг хэрхэн өөрчлөх талаар хүн амын өөр хэл бүхий үндэсний цөөнхийн суралцагч эх хэлээрээ суралцах боломжийг хэрхэн бий болгох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ё.Баатарбилэг ерөнхий боловсролыг заавал эзэмшихтэй холбоотой бага, дунд ангид суралцсаныг баталгаажуулах боловсролын ямар баримт бичиг байх, холимог бүлгээр ахлах ангид хичээллэж болох талаар зохицуулалт тусгасан нь сум, тосгонд хэрэгжүүлэхэд хүндрэл үүсэх тул анхаарах, сургалтын шууд зардалд хамаарах зардлын ангиллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг хуулийн төсөлд боловсролын үнэлгээ мониторингийн талаар ямар зохицуулалт тусгасан, хөдөө орон нутгийн боловсролын байгууллагын төрөөс олгох санхүүжилтэд үүсдэг бодит хүндрэлийг хэрхэн зохицуулсан талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан хүчин төгөлдөр үйлчилж байгаа боловсролын тухай хуулийн зорилтод тусгагдсан сайн зан чанартай иргэн бэлдэх талаарх агуулга тусгагдаагүй байгааг анхаарах, суралцагчийн судлах үндсэн гадаад хэл, англи хэл байх талаарх заалт нь бусад гадаад хэлийг судлахад нөлөөлөх эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан явуулсан хэлэлцүүлгийн үед багш нарын төлөөллөөс өндөр насны тэтгэврийг тогтоолгох насны талаар гаргасан саналыг төсөлд хэрхэн тусгасан талаар, мөн сум дундын ерөнхий боловсролын сургуулийн зохион байгуулалт, сургалтын үйл ажиллагаа явуулах нь олон талын хүндрэл үүсэхэд тул онцгой анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал Монгол Улсын боловсролын салбар, дэлхийн боловсролын чиг хандлагын аль загвараар цаашид хөгжих бодлого баримталж байгаа талаар мөн коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв гэсэн нэршил нь оновчтой эсэх, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир үндэсний цөөнхийн хэлээр суралцагчдад Боловсрол, шинжлэх ухааны яамнаас зөвшөөрөгдсөн сурах бичиг хэрэглэх талаарх заалтыг төсөлд тусгах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг боловсролын тогтолцоонд мэргэжлийн боловсролыг хамруулах талаар боловсролын ашгийн байгууллагыг хэрхэн тодорхойлох талаар, түүнчлэн ашгийн байгууллагад нэг хүүхдэд ноогдох хувьсах зардлыг төрөөс санхүүжүүлэх эсэх, боловсролын салбарын цахим шилжилттэй холбоотой багш нарыг бэлтгэх, чадавхжуулах талаар төсөлд хэрхэн тусгасан талаар болон сурагчдыг сургуульд ирэх очиход тээврийн хэрэгслээр үйлчлэх

талаар тусгах нь нийслэлийн түгжрэлийг бууруулах ач холбогдолтой тул анхаарах, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Монгол Ардын намын сонгуулийн мөрийн хөтөлбөрт заасны дагуу ашгийн төлөө бус боловсролын байгууллагыг бодлогоор дэмжих талаар тодорхой зохицуулалтууд тусгагдсан эсэх, цар тахлын үед зайны болон цахим сургалтын хэлбэр нь суралцагчдад тэгш бус байдал бий болгосныг цаашид хэрхэн арилгах талаар зохицуулсан эсэх талаар төсөл санаачлагчдаас тодруулж, төсөлтэй холбогдох саналуудыг тус тус хэлэлцлээ.

Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн үзэл баримтлалыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон уг хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай хууль, Боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын санхүүжилт, сурагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол Улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах өөрчлөлтийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд оруулах өөрчлөлтийн тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүд болон тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх талаарх Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

**Г.Занданшатар:** Баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, дэд сайд Ганболдын Ганбаяр, Төрийн нарийн бичгийн дарга Дааданхүүгийн Батбаатар, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Жадамбаагийн Ганбаатар, Дунд боловсролын газрын дарга Төмөр-Очирын Ням-Очир, Сургуулийн өмнөх боловсролын газрын дарга Жадамбаагийн Мягмар, Шинжлэх ухааны газрын дарга Содномдаржаагийн Мөнхбат, Содномын Должин Дээд боловсролын газрын дарга, Батсүрэнгийн Мөнгөнбагана Хуулийн хэлтсийн дарга, Жамцын Нарантуяа Бодлого, төлөвлөлтийн газрын шинжээч, Чимэдрэгзэнгийн Баярмаа Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, Төмөрпүрэвийн Намнан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн захирал, Ухнаагийн Туяа Боловсролын хүрээлэнгийн секторын эрхлэгч, Пүрэвдоржийн Оюунаа боловсрол судлаач, PhD, шинжлэх ухаан технологийн их сургуулийн дэд захирал юм байна шүү, Намнан. Очирбат гуай байгаа биз дээ. Тийм.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу.

Балжиннямын Баярсайхан гишүүнээр тасаллаа. Цахимаар 2 гишүүнээр тасаллаа. Хэн хэн гишүүн байна. Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Цахимаар.

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

**М.Оюунчимэг:** Боловсролын тухай хуулийг хэлэлцэх нь бол зүйтэй гэдэг дээр санал нэг байгаа. Ер нь энэ өмнөх 4 жил ч бид ярьж байсан. Үүнээс өмнө ч би бол мэднэ л дээ. Яг тэр үед Засгийн газарт кембрижийн боловсролыг оруулж ирэхэд бас ажиллаж байсан хүний хувьд энэ манай Боловсролын хууль бол бусад хуулийг дагаж өөрчлөгдсөөр байгаад бүр эрэмдэг зэрэмдэг болчихсон байгаа юм. Тийм учраас боловсролын тухай багц хуулиа оруулаад ирээд цогцоор нь хараад томоор хараад алсыг харж оруулж ир ээ гээд бид олон удаа ярьсан. Одоо ингээд бас Энх-Амгалан сайд оруулж ирж байна аа. Тийм учраас хэлэлцэх нь зүйтэй гэсэн байр суурь дээр санал нэг байна.

Ер нь тэгээд зөндөө уншиж судаллаа. Мэргэжлийн хүмүүстэй уулзлаа. Энэ ажлын хэсгийн явцад хэлэлцүүлгийн явцад засаж залруулах, илүү сайжруулах зүйл бол бас зөндөө байна. Одоо бид нар Сингапур, Финлянд, Япон зэрэг орнууд боловсролоороо хүнийхээ оюун ухааныхаа хүчин чадлаар улс орноо өнөөдөр өндөр хөгжүүлчихсэн гол нууц нь юу юм гэхээр ер нь л багштайгаа ноцолдчихсон байдаг. Багшийн бэлтгэх тогтолцоо нь өөрөө маш өндөр, маш чадварлаг байгаад сайн багшаас сайн хүүхэд төрнө. Ер нь дээр үед ч гэсэн манайх тэгдэг байсан юм байна шүү дээ. Багш гэдэг ямар их нэр хүндтэй, мундаг байлаа. Тэгэхээр өнөөдөр багш бэлтгэх тогтолцоогоо тэр жинхэнэ багш хүнийг гаргахад санхүүгийн болоод эрх зүйн хувьд энэ хуулиар тэрийг дэмжсэн ямар бодлого нэгд орж ирж байгаа вэ? Тэгээд хамгийн гол нь бага анги, дунд анги байдаг. Том анги бол угаасаа тэгээд л суурь нь тогтчихсон бол өөрөө багаасаа хүссэн мэргэжлээрээ цаашаа явчих бололцоо бүрдэнэ. Эндээс харахад тэр юмнууд нь бол жоохон ерөнхий байна. Тэгэхээр энэ дээр нэг товч хариулт нэг авъя гэж бодож байна.

2 дахь миний яриад байгаа нэг зүйл байгаа юм аа. Энэ хуулийг ингээд харахад бүхэлдээ мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийг жоохон үгүйсгэсэн, үүнийг бол энэ хуулиараа юуг нь Боловсролын яам руу аваад бас л нэг академик боловсролыг түлхүү өгөх гэсэн нэг зорилго байгаад байна. Тэгэхээр бид нар бас

өнөөдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад хөдөлмөрийн зах зээлийн судалгаанууд хийхэд эрэлт хэрэгцээтэй мэргэжлээ сургахад өнөөдөр манайд байгаа МСҮТ-үүд, тэр дундаа маш чухал үүрэг гүйцэтгэж байгаа МСҮТ байгаа.

Дарга аа, 1 минутаа үргэлжлүүлээд авчихъя.

Тийм учраас би энэ хуулиар мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үнэ цэнийг, хүчин чадлыг, ирээдүйг үгүйсгэж болохгүй гэсэн байр суурьтай байгаа учраас хэлэлцүүлгийн явцад энэ дээр бол өөрчлөх хэрэгтэй. Өнөөдөр яагаад бид нар тэнд 12 жил академийг заавал сурах ёстой гээд. Тэгсэн хэрнээ энэ хуулиас харахад энэ манай өнөөгийн боловсролын тогтолцоо дэндүү хэт ачаалал, гэрийн даалгавар баахан тийм онол заадаг, гэтэл амьдралд хүүхэд бэлтгэгдээгүй байна аа. Тийм учраас нөгөө кембрижийн боловсрол шиг бусад улс орны өндөр боловсрол шиг амьдралд хөрвөх чадвартай тийм боловсон хүчин бэлдэж гаръя аа гэвэл бид мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийг жинхэнэ утгаар нь хөгжүүлэх дээр боловсролын багц хуультайгаа хамтраад хэлэлцүүлээд явчих нь чухал байгаа.

Тийм ч учраас маргааш Ариунзаяа сайд өргөн барих гэж байгаа. Тийм учраас үүнийг би Боловсролын багц хуультай хамтран хэлэлцүүлээд алсыг харсан, ирээдүйд жинхэнэ Монголын хөдөлмөрийн зах зээлд эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр хүн бэлтгэх, тэр юуг давхар хэлэлцээд явах нь зүйтэй байна аа гэсэн байр суурьтай байгаа. Тэгээд энэ түрүүний асуудал ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд асуултад хариулна.

**Л.Энх-Амгалан:** Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Боловсролын хуулийн хамгийн гол амин сүнс нь бол ерөнхийдөө энэ багшийг бэлтгэх, багшийг хөгжүүлэх тогтолцоог одоо бид нар одоогийн байгаагаас жаахан шинэ шатанд гаргая аа гэж байгаа юм. Өнөөдөр одоо манай энэ ерөнхий боловсролын сургууль, сургуулийн өмнөх боловсролд 40 гаруй мянган багш сурган хүмүүжүүлэгч нар байна. Өөрийнхөө чадлынхаа хэрээр л ажиллаж байгаа. Авч байгаа цалингийнхаа хэрээр л ажиллаж байгаа. Тэгээд хамгийн гол асуудал болбол бид нар их ойрхон ойрхон хөтөлбөрийн шинэчлэлүүд хийгдсэн. Монгол Улсад. Их ойрхон ойрхон. Хөдөлмөрийн шинэчлэлүүд 1 дүгээрт хийгдсэн.

2 дугаарт, одоо сургуулийн насыг 7 насыг 6 нас болгоод 10 дугаар ангийн тогтолцоог 12 жилийн тогтолцоо руу ойрхон шилжсэн гэж 3 насыг сургууль дээр их ойрхон хугацаанд хийсэн учраас хөтөлбөрийн шинэчлэлээ дагаад сурах бичиг, арга зүй, багш нар бэлтгэх ёстой. Энэ зүйлүүд нь хийгдэж чадаагүй учраас магадгүй өнөөдөр энэ боловсролын салбарт үүссэн энэ томоохон сорилтууд үүссэн юм болов уу гэж бодож байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ Монгол Улсад 40 сургууль, өнөөдөр магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрөөр багш бэлдэж байгаа. 40 сургууль. Тэгээд ямар хөтөлбөрөөр ямар багш бэлдээд байгаа нь өнөөдөр ойлгомжгүй байгаа байхгүй юу. 1 дүгээрт.

2 дугаарт болохоор ерөнхийдөө манай энэ сургуулийн өмнөх боловсрол, бага ангийн багш болох сонирхолтой хүүхдүүдийн тоо жилээс жилд багасаж байна. Жилээс жилд багасаж байна. Энэ юунаас үүдэлтэй вэ гэхээр мэдээж ажлын

ачаалал, хөдөлмөрийн үнэлэмж, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудал байгаад байгаа юм.

Тэгэхээр бид нар энэ хууль дээрээ ямар зүйлийг оруулж байна вэ гэхээр 1 дүгээрт багш бэлтгэх энэ сургуулиуд, багш бэлтгэх хөтөлбөрөө заавал магадлан итгэмжлэгдсэн байх ёстой гэдэг энэ хуулийн зохицуулалтын нэгт хийж өгч байгаа.

2 дугаарт бид нар багшийн хөгжлийг бол одоогийн байгаа тогтолцоонд 5 жил, 10 жил, 5 жил тутам энэ багшийн мэргэжил дээшлүүлэх энэ хөтөлбөрт хамруулдаг байсан бол одоо бид нар үүнийг багасгаад 3-5 жил тутам мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрт багш өөрийнхөө ажлын байр дээр хөгжих энэ боломжуудыг бид ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо цахимаар Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

**Н.Наранбаатар:** Хөдөө орон нутагт бол энэ хүүхдийн сурах, хүмүүжих, аюулгүй орчин их чухал байдаг юм. Бас манай аймагт бол бас энэ сургуулийн гадна талын хашааны одоо үзүүртэй хашаанд сүлбүүлж шүүхэд тоглож байхдаа эндэж байсан асуудал байдаг. Тэгээд хууль дээрээ бол энэ сургууль, цэцэрлэгийн гадна талын аюулгүй орчин бүрдүүлэх үүргийг зөвхөн сумын засаг дарга, дүүргийн засаг даргад л үүрэг болгочихсон байна. Тийм учраас одоо үүнийг энэ дээр нэмээд сургууль, цэцэрлэгийн эрхлэгч нар, аймгийн засаг дарга хүртэл одоо энэ сургууль, цэцэрлэгийн гадна талын аюулгүй орчныг бүрдүүлэх, хангах, хяналт тавьж байх ийм одоо үүрэгтэй байх аа гэж бодож байгаа. За үүнийг оруулж болох уу.

Мөн энэ сургууль, цэцэрлэгийн эрхлэгч, захирлуудын томилгоо гэж нь аймгийн засаг дарга томилдог байж байгаад өнгөрсөн жилээс сумын засаг дарга томилдог болсон. Тэгээд энэ хуулийн төслөөр бол босоо тогтолцоотой байхаар юм шиг одоо би ойлгосон. Үүнийг бас нэг тодруулаад асуугаадахъя. Хэрвээ тийм бол ойр ойрхон үүнийгээ өөрчлөөд баймааргүй байна. Орон нутгийн, одоо нэгжийн тухай хууль сая батлагдаад орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлж хэвтээ болгох чиглэл рүү болбол энэ хуулийн үзэл баримтлал концепц бол чиглэгдсэн. Тийм учраас орон нутгийн удирдлагууд нь өөрсдөө хүмүүсээ, тэр мэргэжлийн байгууллага нь сонгон шалгаруулаад гарсан хүмүүсийг нь томилдог байдлаар тусгавал зүгээр юм уу гэж бодсон.

Дараагийн нэг асуудал бол хөдөөд ажиллах багш боловсон хүчин, боловсролын байгууллагуудын менежер их дутагдалтай байдаг. Тийм учраас хөдөөд очиж ажиллахад ямар давуу тал бий байх вэ? Хүмүүсийг яаж хотод биш хөдөө рүү явж ажиллах ийм урам өдөөсөн зүйл энд давуу зүйлүүд юу байна вэ?

Мөн багш нарын нийгмийн асуудал, ялангуяа цэцэрлэгийн СӨБ-ын багш нарын хөдөлмөр хүнд ээ гэдэг асуудлыг байнга ярьж байдаг. Энэ тал дээр ямар өөрчлөлтүүд орж байгаа вэ?

Дараа нь энэ чанаргүй олон их дээд сургуулиудаа цөөлөх ямар механизм байна вэ ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд асуултад хариулна.

**Л.Энх-Амгалан:** Маш цөөхөн минутаар хариулж байгаа учраас гишүүд их олон асуулт асууж байна. Тийм учраас би бас зарим асуултуудыг манай сургуулийн аюулгүй орчинтой байдалтай асуудлыг манай Төрийн нарийн бичгийн дарга Батбаатар дарга маш товчхон хариулаадах. Хөдөөгийн багш нарыг яаж дэмжих асуудал хууль дээрээ туссаныг Ням-Очир дарга, багш нарын нийгмийн асуудалтай холбоотой асуудлыг бас Ням-Очир дарга, их, дээд сургуулиуд дээр тавьж байгаа шаардлагуудыг манай Должин дарга ингээд 2, 2 минутад хариулаарай.

Би энэ засаглалтай холбоотой асуудлуудаар нэмэлт мэдээлэл өгчихье гэж бодож байна. Бид нарын энэ боловсролын хуулийн бас нэг гол үндсэн зарчмын өөрчлөлтийн нэг бол энэ боловсролын удирдлагын тогтолцоог аль болохоор оновчтой, улс төрөөс хараат бус мерит зарчимд тулгуурласан ийм боловсролын удирдлагын тогтолцоонд бид нар шилжүүлэе ээ гэж байгаа юм. 2012-2019 онд нийт 783 захирал шинээр томилогдсон байна. Жилд 112 сургуулийн захирал солигддог гэсэн үг. Ингээд 2012-2016 онд нийт 507 захирал солигдсон байгаа юм эрхлэгч. 2016-2019 онд нийт 276 эрхлэгч, захирал солигддог. Нийт шинээр томилогдож байгаа захирлуудын бараг 32 хувь нь буюу 3 захирлын нэг нь бол 5 хүрэхгүй жил энэ боловсролын салбарт ажилласан, ажиллаагүй нь мэдэгдээгүй нэг ийм хүмүүс сургууль, цэцэрлэгийн эрхлэгчээр очдог. Ингээд 10 жил, 5 жил ажиллачихаар тухайн сургууль цэцэрлэгийнхээ эзэн болчихдог нэг ийм тогтолцоонууд бид нар Монгол Улсад байна. Монгол Улсад байна. Тийм учраас цаашдаа бид нар энэ сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтнуудад тавих шалгууруудыг бид нар энэ хуульчилж өгч байгаа юм. Шалгууруудыг хуульчилж өгч байгаа. Хэдэн жил ажилласан байх ёстой юм. Боловсролын арга зүй, бакалавр, магистрын зэрэглэлүүд нь ямар байх ёстой юм гэх мэтчилэнгээр ингээд энэ нэлээн тогтвортой байх, улс төрөөс хараат байх оновчтой байх ийм засаглалын тогтолцоонуудыг бас бид нар энэ хуулиараа хийж өгч байгаа. Ер нь тодорхой ийм зүйл. Шаардлагатай бол одоо бид нар энэ ер нь 5 жилээс дээш нэг сургуулийн захирал хийхэд л их хүндрэлтэй юм ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** 81. Дааданхүүгийн Батбаатар. Төрийн нарийн бичгийн дарга.

**Д.Батбаатар:** Сурагчдын аюулгүй орчинд бол хамгийн ойр байх талаасаа засаг төрийн төлөөлөгчийн хувьд сум, дүүргийн засаг дарга нар байгаа. Зүгээр сая гишүүн болбол хэлж байна, үүнийг аймгийн засаг дарга нарт бас үүрэгжүүлж болохгүй юу гэж байна. Энэ бол бүх хүүхдийн аюулгүй орчныг хангах үүднээс аймгийн засаг дарга нарт бас энэ эрх үүргийг үүрэгжүүлээд тусгаж болно гэсэн ийм бодолтой байна.

**Г.Занданшатар:** Одоо цахимаар Одонгийн Цогтгэрэл гишүүн.

Хэн хариулах юм. Гараа өргөөд хариулаач. Төмөр-Очирын Ням-Очир.

**Т.Ням-Очир:** Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Хөдөөд ажиллах багш нарт ямар давуу тал үүсэх вэ? Ийм зохицуулалт бий юу? Багшийн нийгмийн асуудалтай холбоотой асуудлууд дээр хариулъя. Тэгэхээр яг энэ боловсролын хуулийн нэг шинэчлэлийн гол реформ нь бол энэ боловсролын байгууллагын санхүүжилттэй холбоотой асуудал байгаа. Тэгээд энэ дээр бол багшийн урамшуулал, цалин хөлсний урамшууллын энэ нэмэлт санхүүжилтийн энэ тогтолцоог үр дүнд суурилсан байдлаар бид нар бол оруулж ирж байгаа. Мэдээж

хуучин хуулиуд дээр байсан хот, хөдөөгийн багш нарын нэмэгдэл. Энэ нь бол зөвхөн багшаас гадна бүх бусад бүх ажилтнуудад хамаарах. Мөн багш бус ажилтнуудын ээлжийн амралттай холбоотой энэ зохицуулалтуудыг бас нийгмийн асуудлуудыг нь шийдэх замаар оруулж ирж байгаа.

Мөн хүүхдийн тоо, бүлэг дүүргэлт, хүчин чадлын ашиглалт, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, боловсролын стандарт, багш ажилтны дундаж цалин хөлснөөс хамаарсан сургалтын үйл ажиллагааны шууд зардлыг нормативт зардалд тусгахаар ингэж зааж оруулж ирж байгаа.

**Г.Занданшатар:** 85. Содномын Должин.

**С.Должин:** Нийт Монгол Улсын хэмжээнд дээд боловсролын 88 байгууллагын үйл ажиллагааг чанаржуулахын тулд нэлээн агуулгын хувьд том өөрчлөлт хийсэн. Энэ өөрчлөлтийг хийхийн тулд юуны өмнө бол их, дээд сургуулиудын багш нарын докторын зэрэглэлийн асуудал, мөн олон улсын нэртэй сэтгүүлд өгүүлэл, эрдэм шинжилгээний бүтээлийн шалгуур, мөн оюутан багш нарын харьцаа зэргийг болб шаардлагатай авч үзсэн. Энэ шаардлагыг авч үзэхдээ ангиллыг бол бид нар их сургууль, дээд сургууль, коллеж гэж ангилсан байгаа.

Ер нь хувийн сургуулиудын болон төрийн сургуулийн өмчийн хэлбэрийг бол ялгахгүйгээр олон улсын их сургуулиудын чанар чансааг бол тогтоодог төрийн бус байгууллагуудын ангиллыг бол судалж үзсэн. 2 дугаарт 2010 оны 26 тоот тушаалаар батлагдсан дээд боловсролтой ангиллын журмыг харгалзаж үзээд дээд сургууль, их сургуулиудын чанарын үзүүлэлтийг бол нэлээн өндөр түвшинд шалгуурыг авч үзсэн. Тухайлбал зүгээр их сургууль дээр жишээ авч үзэхэд бол 5-аас доошгүй магистрын, 5-аас доошгүй докторын хөтөлбөртэй, 15-аас доошгүй магистрын хөтөлбөртэй. Үндсэн багшаа 50-аас доошгүй хувийн докторын зэрэглэлтэй, мөн 60-аас доошгүй хувь нь бол эрдэм шинжилгээний бүтээлийг шалгууруудыг болбол тавьж ангилж үзсэн. Ингэснээрээ энэ зүгээр механик одоо чанарын үзүүлэлт, чанарын өрсөлдөөнийг бий болгож байгаа биш энэ зах зээлийн өрсөлдөөндөө боловсролын байгууллагууд бол хөтөлбөрийн магадлан итгэмжилсэн хөтөлбөрт, өөрөөр хэлбэл магадлан скот хөтөлбөрөөр орсон их сургуулиудын тоог болбол тэр шалгуурт хүрэхэд нэлээн өндөр шалгууруудыг тавьж томоохон өөрчлөлтийг бол хийсэн.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл

**О.Цогтгэрэл:** Баярлалаа. Боловсролын хууль маш чухал хууль орж байна. Тэгээд тодруулж 3 асуулт асууя.

Ер нь аливаа хууль шинэчлэл, тэр тусмаа энэ чинь цаана нь явсаар явсаар байгаад байгууллагын харилцаан дээр очиж байдаг. Тэгэхээр үүний цаана бараг тодорхой хэчнээн гоё олон зүйл зарчим, олон зүйл ярьсан чинь 2 зүйл, заавал удирдах зохион байгуулалт нь зарчимтай, хараат биш тэр тусмаа улс төрөөс хараат бус байж чадаж байна уу? Санхүүжилтийн асуудал гэдэг 2 зүйл. Дунд сургуульд ч хамаатай байх. Тэр тусмаа их дээд сургууль. Их, дээд сургуулийн захирлын томилгоог энэ хуулиар яаж хийх вэ? Одоо бол нэг ТУЗ нэртэй удирдах зөвлөл нэртэй байгууллага байдаг. Баахан төрийн албан хаагчид орчихсон. Тэгээд тэндээсээ 4 жил тутамд бараг ингээд солигдоод явдаг. Тэгэхээр энд их, дээд сургуулийн захирлын томилгоо энэ хуулиар хэрхэн яаж хийгдэх вэ, энэ дээр ямар дэвшил гарч байгаа вэ.

2 дугаарт нь, санхүүгийн эрх мэдэл, санхүүгийн бие даасан байдлыг яаж хангах гэж байгаа юм. Яг одоо дахиад их, дээд сургууль, тэр их, дээд сургуулийн түвшинд бол улсаас санхүүжилтийн нэг оюутны төлбөрийг нь тогтоочихдог. Тэгэхээр тэр санхүүгээ олохын тулд хөрөнгөө босгохын тулд төлбөр нэг оюутны төлбөр хэвэндээ, 300 оюутны хүчин чадалтай, материаллаг баазтай болбол бараг л мянгыг авчихдаг, 3000-ыг авчихдаг. Ингээд нөгөө чанаргүй боловсон хүчин чинь энэнээс цаана ингээд улбаалаад гарчих ирнэ. Тэгэхээр ер нь энэ сургууль сургалтын төлбөрийн асуудлыг одоо яг энэ хуулийн хүрээнд, яг ямар байдлаар цаашид энэ чинь цааш цаашаагаа, санхүүгийн бие даасан байдлын тухай яриа болоод явчихдаг том зүйл байдаг учраас хэчнээн гоё хууль гаргачихаад улсаас үнийг тогтоогоод байх юм болбол энэ хоёр чинь ингээд утгагүй болох байх аа гэж. Тэгэхээр энэ дээр ямар ахиц дэвшил гарч байгаа вэ.

3 дугаарт нь, их сургуулиудыг нь судалгааны их сургууль болгох гэдэг нэг ойлголтын хүрээнд ямар ахиц дэвшил гарч байгаа вэ? Үүний цаана Шинжлэх ухааны академийн харилцааг яаж шийдэж байна, хуульд ямар байдлаар одоо тусаж байгаа вэ? Цаашдаа энэ бас тусдаа ч эрх зүйтэй байх алсын хараагаа юу гэж харж байгаа юм? Их сургууль хэрхэн яаж одоо бодлого чиглэлийн хувьд, үйл ажиллагааны хувьд ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Их, дээд сургуулиудын удирдлагын тогтолцооны тухайд манай Ганбаяр дэд сайд энэ дээр тодорхой хариулт өгөөрэй.

Санхүүжилтийн хувьд бол ямархуу санхүүжилтүүд явах вэ гэдэг дээр манай Должин дарга, ингээд цаашдаа энэ судалгааны их, дээд сургуулиуд, ер нь их, дээд сургуулиуд цаашаагаа ямар зохион байгуулалттайгаар, ямар санхүүжилтээр явах вэ гэдгийг манай Намнан зөвлөх энэ дээр одоо бас хариултуудаа өгөөрэй гэж бодож байна.

Би ерөнхийдөө ер нь боловсролын бүх түвшинд энэ удирдлага зохион байгуулалт, санхүүжилтийн ямархуу зарчим концепцууд бий болж байгаа юм бэ гэдгийг бас хэлье гэж бодож байгаа юм. Тэгэхээр бид нар боловсролын чанар, үр дүнд гүйцэтгэсэн ийм санхүүжилтийн тогтолцоо руу бид нар шилжинэ ээ. Бид нар чанарыг нь үнэлнэ, үр дүнг нь үнэлнэ, гүйцэтгэлийг нь үнэлж бид нар тодорхой санхүүжилт өгдөг ийм тогтолцоо руу бид нар шилжье гэж байгаа юм. Ерөнхийдөө бид нар энэ санхүүжилтийн 4 хэлбэрийг бид нар шилжинэ.

1 дүгээрт нь ер нь бүх түвшний сургуулийн өмнөх боловсрол болон дунд боловсрол, дээд боловсрол, мэргэжлийн боловсрол ч энд хамаарна. Ер нь сургуулиуд хагас бие даасан энэ тогтолцоонд шилжих ийм зайлшгүй шаардлага байна.

2 дугаарт нь нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын санхүүжилтийн аргачлалыг бид нар шинэчилнэ.

3 дугаарт нь болбол сургуулийн бүтэц, байршил, хэв шинжийн оновчтой хувилбаруудыг бид нар тогтооно.

Ингээд 4-т нь бид нар сургалтын чанарт суурилсан багшийн цалин урамшууллуудын тогтолцоог бий болгох ийм санхүүжилтийн 4 хувилбар буюу 4

зарчмыг бид нар энэ хуулийнхаа хүрээнд хийх юм байгаа юм. Тэгэхээр өнөөдөр сургалтын хөтөлбөр, хичээл нэг бүрийг бодит өртөгт суурилсан энэ санхүүжилтийн энэ тогтолцоо руу шилжих ийм зайлшгүй шаардлага байна гэж байгаа юм. Өнөөдөр ширээ, сандал, тоног төхөөрөмж компьютеруудыг заавал улсын төсвийн хөрөнгө оруулалтаар яамнаас өнөөдөр 330 сум дээр байгаа сургуульд хуваарилагдах биш сургуулийнх нь урсгал зардалд нь элэгдэл зардлуудыг нь суулгаж өгөөд ширээ сандал, лабораторийн тоног төхөөрөмж компьютеруудаа сургууль өөрсдөө бие дааж шийдэх энэ санхүүгийн эрх чөлөөг нь бас үе шаттайгаар шилжүүлнэ. Мөн сургуулийн ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** 84, Ганболдын Ганбаяр дэд сайд.

**Г.Ганбаяр:** Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Төрийн өмчийн их, дээд сургуулиудын захирлыг өнөөдрийн хуулиар бол Боловсролын сайд томилж, чөлөөлдөг. Төрийн албаны тухай хуулийг үндэслэн томилж чөлөөлж байгаа.

Өнөөдрийн өргөн мэдүүлж байгаа, хэлэлцэх эсэхийг нь хэлэлцүүлж байгаа энэ хуулиа хэрвээ батлагдаад явах юм бол их, дээд сургуулиуд, ер нь цаашдаа бол корпорацийн зарчим руугаа шилжиж зах зээлийнхээ эрэлт хэрэгцээ нийлж санхүү төлбөрийн хувьд ч гэсэн нэлээн либеральчлагдаж. Үүнийгээ дагаад бол их дээд сургуулийн захирал бол төлөөлөн удирдах зөвлөлийнхөө хурлаар мерит зарчмаар томилогдож, чөлөөлөгддөг энэ зарчим руу шилжихээр энэ хуулийн үндсэн концепц бол чиглэгдээд явж байгаа. Ер нь бол цаашдаа их, дээд сургуулиудын энэ шилжилт бол илүү дэлхийн чиг хандлага руугаа нэлээн шилжих ийм зүйл орно.

2 дугаарт энэ хууль батлагдсанаараа бол их, дээд сургуулиуд дээр тавигдах шаардлагууд нэлээн өндөрсөхөөр механик энэ сургуулиудын нэгдэл. Одоо энэ зүйлүүд бол нэлээд явж байна. Их, дээд сургуулиудын тоо бол нэлээн буурч, чанар нэлээн ахих ийм хүлээлттэй байгаа.

**Г.Занданшатар:** 85.

**С.Должин:** Их сургууль, их сургуулиудын санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтыг шинээр төсөл боловсруулж байгаа төсөлдөө оруулахын тулд нэлээн судалгаа хийсэн. Ерөнхийдөө бол харьцуулсан гадаад орнуудын туршлага болон Монгол Улсын дээд боловсролын хуулийн 10 өөрчлөлт нь санхүүжилтийн тогтолцоог яаж одоо өөрчлөхийг бол бид нар нэлээн судалгаатай хийсэн. Тухайлбал, манай Монгол Улс бол санхүүжилтийн дээд боловсрол, санхүүжилтэд жилдээ 0,1 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний Япон улс гэхэд 3,2, Солонгос бол 4,2 хувийг, Америкийн нэгдсэн улс 2,4 тэрбумыг дээд сургуулийнхаа санхүүжилтэд зарцуулдаг юм байна аа. Бид нар бол энэ санхүүжилтийн эрх зүйн зохицуулалтаа яаж тодорхой болгож өгсөн бэ гэхээрээ хамгийн анхаарсан гол зүйл багш, судлаачдын сургалтын үйл ажиллагаа, судалгаандаа олсон орлогоо эргээд яах нь оюуны бүтээлдээ эргэлтэд оруулах зохицуулалтыг бол тодорхой 3 хувь, 5 хувиар тусгайлан их, дээд сургууль гэж ялгаж зохицуулж өгсөн. Санхүүжилтийн асуудал дээр. Энэ төслийг нэлээн гол давуу тал болж өгсөн. Өөрөөр хэлбэл төрөөс төрийн ивээлд болж төрийн өмчит сургуулиудын багш судлаачдын оюуны бүтээлээр орсон орлого нь эргээд тухайн үйл ажиллагаандаа зарцуулах эрх зүйн зохицуулалтыг бол энэ хуулийн төсөлдөө бол оруулсан.

**Г.Занданшатар:** 95. Намнан ШУТИС-ийн дэд захирал.

**Т.Намнан:** Би товчхон хариулъя. Энэ ер нь орчин цагийн их сургууль бол судалгаа хийж, мэргэжилтэн бэлтгэхээс илүүтэй мэдлэг бүтээж, инновацыг бий болгож, судалгаа хийж энэ улс орны нийгэм эдийн засгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд гол үүрэг оролцоо, үйл ажиллагаанд чиглэх болсон. Энэ ч утгаараа Монгол Улс бол энэ олон улсын жишиг чиг хандлагаар судалгааны их сургуулийг байгуулах замаар энд илүү, одоо төвлөрлийг, хүний нөөцийг бид аль болох хүн, аль болох бүх талын нөөцийг тарамдуулахгүй, зөв судалгааны менежментийг зохион байгуулалттай хийж, энэ эх орны улс орны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, эдийн засгийн чадавхыг дэмжихтэй холбоотой тэргүүлэх чиглэлтэй холбоотой Монгол брэндийг дэлхийн тавцанд гаргаж болох энэ чиглэл рүү судалгааг төвлөрүүлж, бүх талын нөөцийг энэ рүү бий болгох зарим зохицуулалтыг оновчтой хийх энэ арга барилаар бид хандсан. Тэгэхээр үүнтэй холбоотой зохицуулалтыг бол хуульд тодорхой тусгаж өгсөн гэж ойлгож байгаа.

Ингэхийн тулд судалгааны их сургууль маань өөрөө яах вэ, судалгаа, их сургууль бол өөрөө ангиллаараа судалгааны, мэргэжлийн, сургалтын их сургууль гээд олон ангилалтай байгаа л даа. Хэв шинжээрээ дотроо. Тэгэхээр бид бол аль болох одоо судалгааны их сургуулийг Монгол Улс бий болгож хөгжүүлэх, тэгэхдээ энд нь санхүүгийн болоод засаглалын хувьд бие даасан тогтолцоог бий болгох чиглэлд нь эрх зүйн зохицуулалтуудыг хийж өгсөн гэж ойлгож байгаа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя. 1 минут.

**О.Цогтгэрэл:** Саяын асуудлууд дээр ингээд тодруулъя. Дахиад тэр захирлын томилгоог сайд биш ТУЗ томилдог гэхээр ТУЗ чинь өөрөө дахиад л хэдэн төрийн албан хаагчид тэнд сууж байгаа шүү дээ. ТУЗ-д нь. Энд тэндээс орчихсон хэдэн төрийн албан хаагч сууж байгаа. Дахиад л нөгөө улс төрийн хараат байдал чинь хэвээрээ л байх юм шүү. Тэгэхээр тэр сонгон шалгаруулалтын хороо, комисс байдаг юм уу, нээлттэй сонсгол нь байдаг юм уу, бүр илүү тийм олон нийтийн оролцоо руу нь энэ их, дээд сургуулийн захирлын томилгоог чинь жаахан оруулах юм биш үү.

2 дугаарт нь тэр санхүүжилтийн эх үүсвэр дээр тэр олон тайлбар биш би ер нь оюутны сургалтын төлбөрийг нь төрөөс тогтоогоод байдгийгаа болих юм уу, энэ тодорхой хэмжээний тэр сургуульд нь зах зээлийн зарчмаар эрх хэмжээ очих юм уу гэдэг асуудал л асуулт тавьсан. Тэрэн дээр тодорхой хариулт өгмөөр байна.

3 дугаарт нь тэр судалгааны их сургууль гэдэг зүйл яригдахаар заавал үүнийг дагаад тэр Шинжлэх ухааны академийн эрх зүй гэдэг асуудлыг заавал яригдаж таарах юм шиг байгаа юм. Яг энэ дээр ямар байр суурь, Шинжлэх ухааны академийг цаашдаа яах юм.

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Их, дээд сургуулиудын засаглалын асуудал бол ер нь улс орны хөгжлийн онцлогоос шалтгаалж их олон хэлбэрүүд байдаг юм байна лээ. Ер нь хувийн ч бай, хувьсгалын ч бай цаашдаа ер нь энэ корпорацийн засаглал бол бид нар үе шаттайгаар шилжих ийм зайлшгүй хэрэгцээ шаардлага өнөөдөр үүсэж байна гэж байгаа юм. Тэгэхээр одоо ашгийн болон ашгийн бус гэж байж болно гэж бид нар хуульдаа тодорхойлж өгсөн. Ашгийн төлөө байж байгаа, байгуулагдаж байгаа их дээд сургуулиуд бол байх юм бол компанийн хуулиараа зохицуулагдаад явна аа. Ер нь захирлын томилгоог одоо бид нар дээд боловсролын үндэсний

зөвлөл гэж төрийн өмчит их дээд сургуулиудын, одоо бодлогыг тодорхойлдог энэ үндэсний зөвлөлийг бид нар бий болгоно. Тухайн сургууль дээр бол удирдах зөвлөл бий болно. Ингээд эрдэмтдийн зөвлөл гэсэн ямар ч байсан одоо ингээд нөгөө засаглалын менежментийн байх ёстой дэлхийн улс орнуудад байдаг хамгийн зөв хэлбэрүүдийг бид нар сонгоно. Тэрнээс биш өнөөдрийн байгаа энэ сайдын үзэмжээр, сайдын үзэгний үзүүрээр хэн нэгний одоо хувь заяа шийдвэрлэгддэг. Ийм улс төрийн тогтворгүй оновчгүй мерит зарчим дээр тулгуурлаагүй энэ тогтолцооноос бид нар салах ёстой юм байгаа юм. Ер нь 2016 он, 2015 онд батлагдсан хууль бол сайн хууль болсон. Үүнээсээ бид нар бол нэг алхам жаахан ухарчихсан байгаа. Тийм учраас одоо нэгэнт нийгмийн ийм захиалга, нийгмийн хүлээлт байгаа учраас бид нар их, дээд сургуулийнхаа Монголынхоо улсын хөгжлийн хэрэгцээ шаардлага дээр нийцсэн ийм их, дээд сургуулиудын тогтолцоонд шилжихийг л хүсэж байгаа болбол хүссэн хүсээгүй бид нар энэ олон улсад байдаг корпорацын энэ засаглал руу, үе шаттайгаар шилжих ийм шаардлага байна аа.

Ер нь их, дээд сургуулиудын төлбөрийг бид нар төрөөс одоо хатуу хянахгүй ээ. Өнөөдөр чанартай их дээд сургуулиуд, чанартай хөтөлбөр, чанартай багш нарынхаа араас одоо явах энэ тогтолцоог бид нар энэ эрх зүйн орчноороо дэмжиж байгаа. Тийм учраас болбол энэ сургуулийн төлбөрт хэдэн төгрөг байна гэдэг ийм хатуу, одоо тогтолцоо байхгүй. Цаашдаа бол хүүхэд бүхэн өнөөдөр их, дээд сургуульд орох шаардлага байхгүй байгаа. Тэгэхээр өнөөдөр мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, коллеж, 12 жилийн боловсролын тогтолцоогоо бид нар хийхэд бол одоо тодорхой ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Сая сайн хариулсангүй л дээ. Одонгийн Цогтгэрэл гишүүн өмнөөс нэг юмыг тодруулбал ер нь өмнө нь 2016 оны билүү дээд боловсролын хуулиар хараат бус байдлыг ТУЗ-ийн хараат бус байдлыг бол нэлээн хангасан байсан шүү дээ. Тэрийгээ сүүлд нь аваад хаячихсан. Тэгээд тэрнийгээ саяынхаа эргэж тэр байдалд нь бүрэн оруулж чадсан уу? Энэ хуулийн төсөл дээр бол ороогүй. Тэр дээд боловсролын академик эрх чөлөө, хараат бус байдлыг хангах агуулга ер нь яг бүрэн суусан юм уу?

Байнгын хороо. Гонгорын Дамдинням гишүүн хариулъя.

**Г.Дамдинням:** Цогтгэрэл гишүүний асуусан асуулт болон бас өмнө нь нийт асуусан гишүүдийн асуултад ерөнхийд нь Байнгын хорооны зүгээс барих бодлогын хүрээнд нэг хариулт өгчихье гэж бодлоо. Өнөөдөр болбол бид нар энэ боловсролын тухай багц хуулийн үндсэн одоо багц хуулийг хэлэлцэх эсэхийг хэлэлцээд явж байна. Энэ зун, намрын турш бид нар болбол бүх оролцогч талуудыг хамарсан өргөн хэмжээний хэлэлцүүлгүүдээ явуулна аа. Тэгэхээр Цогтгэрэл гишүүн болон бусад гишүүд энэ хуулийн төсөлд оруулах саналтай байгаа бичиг саналуудаа бичгээр, ажлын хэсгүүд байгуулагдахаар өгөөрэй. Тэрэн дээр нь болбол хэлэлцүүлгүүдээр оруулаад хамгийн энэ бүх оролцогч талууд, эцэг эхчүүд эхүүд, тэгээд сурагчид, оюутнууд, сургуулийн орчинд ажилладаг хүмүүс, багш нар профессорууд, ингээд энэ бүх оролцогч талуудын зөвшилцлөөр энэ хуулийг батална гэсэн ийм бодлого барина. Тэгэхээр та бүхэн өнөөдөр болбол хэлэлцэх эсэх тухай асуудал яригдаж байгаа гэдгийг бас дахиад хэлчихье.

Бүх эрх мэдэл бол мэдээж Улсын Их Хуралд байгаа. Тэгээд ямар маягаар авч гарахыгаа болбол бид нар хоорондоо ярилцаж байгаад шийднэ ээ. Тэгэхээр

одоогийн байдлаар бол бүх саналуудад нээлттэй хандаж байгаа шүү гэдгийг л хэлэх гэсэн юм аа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Одоо Бадарчийн Жаргалмаа гишүүн.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа, би 1 л зүйлийг тодруулах гэсэн юм аа. Би өөрөө Боловсрол соёл, шинжлэх ухааны байнгын хорооны гишүүн. Энэ хуулийн төсөл хэлэлцэгдэж эхлэхтэй зэрэгцээд л бүс нутагт багш нартай олон удаагийн хэлэлцүүлгийг бас зохион байгуулж байсан. Тухайн үед багш нар юу хүсэж байсан бэ гэвэл нийгмийн асуудал, үнэлэмжийн тухай маш олон саналыг бас ирүүлж байсан. Эдгээр саналууд бас энэ хуулийн төсөлд туссан.

Нөгөөтээгүүр ард нийтээрээ хуулиа хэлэлцдэг байх цахим парламенттай болсны хувьд май парл, май форумгаар бас олон хүмүүс бас саналаа ирүүлснийг ажлын хэсгийнхэн, хуулийн төслийнхөн бас авсан байх аа гэж би бодож байна аа. Ер нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд буюу хүүхдүүд дээрээ тэгш хамран сурах сургалт гэдэг 3 дугаар бүлгийг оруулж ирж нийтдээ 9н зүйл заалт бүхий энэ хуулийн төсөл оруулж ирж байгаа. Энэ дээр би 1 зүйлийг тодруулах гэсэн юм аа.

Яг өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэмжээнд 9722 хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгсэлт хүүхэд байгаагаас нийтдээ 2680 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж чадахгүй байна аа гэсэн ийм тоо баримт байгаа. 2019-2020 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй сурах сурагчдыг ердийн сургуульд суралцуулах боломжийг бас Соёлын сайд, уучлаарай Боловсролын сайд бас нээж өгсөн байгаа. Журам гаргаж. Ингэснээрээ хүүхдүүд энгийн сургуульд суралцах боломж нээгдэж байгаа боловч энгийн сургуульд очоод хүүхдүүдтэй хамт суралцах боломжгүй ийм хүүхдүүд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд байгаа. Өөрөөр хэлбэл байнгын асаргаатай хүүхдүүд маань сургалтад хамрагдаж чадахгүй байгаа. Тэгвэл энэ одоо тэгш хамран сургалт гэсэн энэ хуулийн зүйл заалт орж ирснээрээ бид бүх хүүхдүүдээ ерөнхий боловсролын сургуульд хамрах тэр боломж бий болж байгаа юу? Хөгжлийн бэрхшээлтэй буюу тусгай хэрэгцээт хүүхдүүдэд сургалт явуулахад маш хүнд байдаг аа. Багш нараа энэ асуудал дээр хэрхэн яаж дэмжих юм. Магадгүй байнгын асаргаатай хүүхдүүддээ тийм ээ, одоо эмч сувилагчийн асаргаа үзүүлэх тэр боломжийг ер нь энэ зүйл заалтууд хангалттай оруулж өгсөн байгаа юу? Ингэснээрээ ер нь бол ерөнхий боловсролын сургуулийн багш ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Жаргалмаа гишүүн нэмэлт 1 минут.

**Б.Жаргалмаа:** Энэ зүйл заалт орж ирснээрээ Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын 87 орчим хувь нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг уг нь энгийн сургуулиас илүү тусгай сургуульд сургах ёстой гэдэг ийм байр суурь баримталдаг байсан. Энэ зарчмыг эцэслэж чадсан бол уу? Ер нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үнэлэх, сургах нэгдсэн стандарт, үнэлгээний ачлаа байхгүй, багш нар нь тэгш хамруулан сургах боловсролын талаар тодорхойгүй эргэлзсэн ийм хоёрдмол байр суурьтай байсан. Ийм зүйл заалт орж ирснээр энэ асуудал шийдэгдсэн болов уу гэдэг асуултыг асуух гэсэн юм аа.

**Г.Занданшатар:** Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Жаргалмаа гишүүн ээ, бид нар ер нь энэ цаашдаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд гэж ер нь хэлэхээсээ

их болгоомжлох хэрэгтэй юм байна лээ. Боловсролын ялгаатай хэрэгцээ гэж бид нар үүнийгээ зөв засаж залруулахгүй болбол ер нь ард иргэдийнхээ нэг хэсгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхдүүд гэж ингэж алгалан гадуурхах ч болохгүй юм байна лээ. Хуулийнхаа нэрийг ч гэсэн цөмөөрөө ер нь яваандаа нэг өөрчлөх ёстой юм байна гэж бодож байгаа. Жаргалмаа гишүүн ээ. 1-д,

2-т болохоор үнэхээр энэ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо жил бүхэн өсөж байна. Энэ их сэтгэл эмзэглүүлж байгаа. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд бараг 140-өөд мянган иргэд хөгжлийн бэрхшээлтэй. Тэрнээс одоо бараг үндсэндээ 10 мянга гаруй хүүхдүүд болбол ингээд хөгжлийн одоо ялгаатай, боловсролын ийм ялгаатай хэрэгцээ шаардлага өнөөдөр үүсэж байгаа юм. Тэгэхээр энэ хүүхдүүдийг өнөөдөр Үндсэн хуулиар олгогдсон сурч боловсрох эрхээр бид нар яаж хангах вэ гэдэг Монгол төрийн том сорилт юм байна гэж харж байгаа юм. Тэгэхээр одоо тусгай сургуулиуд байгуулаад тусгай цэцэрлэгүүд бариад ингээд бид нар нийгмээс улам тусгаарлаад байх уу? Эсхүл өнөөдөр ердийн цэцэрлэг, сургуулиараа дамжуулж энэ боловсролын ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүддээ боловсрол олгох уу л гэдэг ийм асуудал байгаа юм.

Тэгэхээр дэлхий нийтийн чиг хандлага болбол ингээд боловсролын ялгаатай энэ хэрэгцээг ердийнхөө сургууль, ердийнхөө цэцэрлэгээр дамжуулж олгодог. Үүний тулд бид нар багшаа бэлддэг, хөтөлбөрөө бэлддэг, агуулгаа өөрчилдөг, одоо мэдээллийн шинэ технологи дээр суурилсан ийм сурах арга зүйн технологиудыг нэвтрүүлдэг ийм сайн туршлагууд байна, сайн туршлагууд байна. Тийм учраас бид нар цаашдаа энэ боловсролын ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүдээ сургах чиглэл рүү хэдийгээр бид нар хууль дээрээ томоохон заалтууд, одоо явуулын багш ажиллуулахаас авхуулаад, тухайн хүүхдийн тэр бэрхшээлээс одоо сонсголын гэдэг юм уу, харааны гэдэг юм уу, хөдөлгөөний гэдэг юм уу үүнээс нь онцлогоос нь шалтгаалж байгаад бид нар одоо тодорхой насных нь онцлогт тохирсон, мөн сургалтын ямар хэлбэрээр тухайн насны хүүхдэд яг ямар хэрэгцээтэй сургалтуудыг сурах ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нэмэх хүн байгаа юу. Алга байна.

Түрүүн бас нээрээ Одонгийн Цогтгэрэл гишүүн тэр шинжлэх ухааны академийн статусыг бас цаашид яах юм бэ? Энэ академик эрх чөлөөтэй холбогдуулж л асуусан.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүн асуулт асууя.

**Г.Тэмүүлэн:** Боловсролын ерөнхий хуультай холбогдуулаад нэг хэдэн зүйлийг бас хэлье ээ. Тодруулж асууя аа л гэж бодож байгаа юм. Тэгээд ер нь болбол бид нар энэ боловсролынхоо салбартаа энэ эрх зүйн шинэчлэлийг хийх зайлшгүй шаардлагатай. Тэгэхээр аливаа улс орны хөгжил дэвшил бол мэдээж энэ боловсролынх нь салбараас хамаардаг. Тухайн тэр сургалтынхаа чанараас хамаардаг. Тэгээд нэг зүйлийг би орхигдуулсан байна гэж хараад байгаа юм. Нэг зүйлийг орхигдуулсан байна. Боловсролынх ерөнхий хууль дээрээс.

Бид нар энэ боловсролынхоо салбарыг яаж энэ улс төрчдөөс ангид байлгах юм бэ. Улс төрийн намуудаас энэ хараат бус байлгах юм бэ гэдэг асуудал бол энд ороогүй байна аа. Би хувь хүнийхээ үүднээс 3 сарын 19-нд Улсын Их Хуралд энэ хуулийн төслийг өргөн барьсан. Боловсролын салбарыг улс төрчдөөс ангид байлгах, боловсролын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг

өргөн баригдсан. Энэ хуулийг бас хэлэлцэх зайлшгүй шаардлагтай байгаад байгаа юм. Тэгээд би энэ асуудлыг зүгээр хэдхэн тоогоор бас хэлье гэж бодоод байгаа юм. Юу вэ гэхээр өнөөдөр Монгол Улсын хэмжээнд нийтдээ 2293 боловсролын байгууллага байгаад байгаа юм. Сургууль, цэцэрлэг байгаад байгаа юм. Үүн дотроос нь аваад үзэх юм болбол 829 ерөнхий боловсролын сургууль, 1454 цэцэрлэг байгаад байгаа. Эдгээрийн ард гээд аваад үзэх юм болбол нийтдээ нэг 84 мянган багш нарын асуудал байгаад байгаа юм. Сонгууль болгоны дараа. Орон нутгийн сонгууль болгоны дараа бүх халаа сэлгээнүүд хийгддэг юм. Энэ бид нар гоё сайхан зүйлийг яриад байдаг. Энэ боловсролын салбар чинь өөрөө бид нар яаж энэ улс төрчдөөс ангид байх юм. Энэ халаа сэлгээ, томилгоог бид нар яаж эрүүл зөв байлгах юм гэдэг асуудал чинь байхгүй болчихлоо.

Өнөөдөр энэ 84 мянган багш нарын асуудал. Энэ 2293 буюу 2300 гаруй сургууль, цэцэрлэгийн чинь эрхлэгч нар сонгууль болгоны ард дээр өөрсдийнхөө улс төрийн үзэл баримтлалаас хамаарч халагдан солигдох нөхцөл байдлаас чинь болж болбол 84 мянган багш нарын ажлын байрны асуудал хөндөгдөж байна аа. 10, 20 хувь нь ажлаас халагдаж байна аа. Тэдгээрийн ар дээр аваад үзэхээр нэг сая хүүхдийн эрх ашгийг хөндөгдөөд байгаа юм. Тэрний ард байгаа нэг сая одоо юу гэдэг юм хоёр сая, магадгүй тэр эцэг эхчүүдийн асуудал энэ чин хөндөгдөөд байна. Энэ асуудлыг бид нар цэгцлэхгүй бол болохгүй болчихоод байна аа. Байнгын хороо бид нар яагаад энэ асуудлыг хэлэлцэхгүй байна аа? 3 сарын 19-нд би хуулийнхаа төслийг өргөн барьсан. Өнөөдрийг хүртэл хэлэлцэх ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тэмүүлэн гишүүн нэмэлт 1 минут.

**Г.Тэмүүлэн:** Тэгээд бид нар энэ асуудлыг ер нь боловсролын салбарыг улс төрчдөөс ангид байлгахгүй бол энэ 84 мянган хүн чинь болбол байнгын халагдаж солигдоно. Сонгууль болгоны дараагаар улс төрждөг асуудал хэвээрээ байна аа. Үүний бодитод бодит нэгхэн жишээг хэлье.

Сүүлийн 4 жилийн хугацаанд 1800 гаруй хүн анхан шатны шүүх дээр гомдол гаргасан байна. Энэ 2300 гаран энэ сургууль, цэцэрлэгийн чинь бараг магадгүй дийлэнх нь бүгдээрээ шүүхэд хандаж байна. Энэ бодлогын энэ алдаанаас чинь болоод тогтолцооны гажуудлаас чинь болоод шүүх дээр одоо хүртэл энэ ачааллыг нэмж байна шүү дээ. Тэгэхээр одоо яг Боловсролын яам энэ дээр ямар байр суурьтай байгаа юм? Яагаад үүнийг нь хэвээр нь байлгах гээд байгаа юм. Яагаад үүнийг өөрчлөхгүй байя гэж бодоод байгаа юм. Байнгын хороо энэ асуудлыг хэзээ хэлэлцэх юм бэ? Хэлэлцэх асуудлыг нь дараалалд оруулж өгөөд ирэх долоо хоногоос хэлэлцээд 2 хуулийг нэгтгээд яваач ээ. Хэдүүлээ хамтраад ярья, болохгүй зүйлийг нь хийе, нэмэлт өөрчлөлтийг нь ярья. Миний боловсруулсан хуулийн төсөл одоо бэлэн байна, энэ дээр ярилцъя аа л гэсэн саналыг хэлэх гээд байгаа юм. Та хэд маань тайлбар хариулт өгөөч?

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд, дараа нь Байнгын хорооны дарга.

**Л.Энх-Амгалан:** Тэмүүлэн гишүүн их чухал хуулийн санал өргөн барьсан. Ер нь анх хуулийн концепц ярилцаж байх үед болбол ерөнхийдөө энэ боловсролын салбарын реформ хийж байгаа улсууд боловсролынхоо салбарын шинэчлэлийг тогтвортой залгамж бодлоготой хэрэгжүүлэх тогтолцоо нь болбол энэ босоо тогтолцоо л юм байна лээ, босоо тогтолцоо. Тэгэхээр одоо ингээд бид нар үндсэндээ энэ орон нутгийн сонгууль, Их Хурлын сонгуулийн дараа ингээд

ерөөсөө дандаа энэ төрийнхөө ганцхан энэ боловсролын тогтолцоо биш л дээ. Ер нь төрийн албаныхаа энэ тогтолцоог хэвтээ болгоод босоо болгоод, ингээд маш тогтворгүй болгоод явчихсан нэг ийм нөхцөл байдал үүссэн. Тэр тусмаа өнөөдөр энэ боловсролынхоо салбараар бид нар бас ингэж хамаагүй тоглож болохгүй юм байгаа юм аа. Тийм учраас өнөөдөр бид нарын түвшинд одоо ямар хуулийн төслийг бид нар өргөн барьчхаад байгаа юм бэ гэхээр ямар ч байсан нэг дурын засаг дарга, сумын засаг дарга, аймгийн засаг дарга, одоо ингээд нэг өөрийнхөө хүссэн гудамжинд явж байгаа нэг хүнийг сонгуулийн үр дүнгээр манай нам ялсан гээд нэг намынхаа үзэл бодлоор ингээд боловсролд ажиллаагүй, мэдлэггүй, чадваргүй хамт олон нь хүлээн зөвшөөрдөггүй ийм хүнийг о хүчээр тавьдаг энэ тогтолцооноос л бид нар салмаар байна.

Өнөөдөр Мал эмнэлгийн ерөнхий газар гэхэд сумдаа хүртэл мал эмнэлгийнхээ эмчийг томилж байхад яагаад энэ боловсролын салбарын реформ хийж байгаа энэ үед Боловсролын яам, боловсролын агентлаг, агентлаг нь аймгийн боловсролын газрын даргаа томилоод, боловсролын газрын дарга нь сургууль, цэцэрлэгийнхээ эрхлэгчийг томилоод явж болдоггүй юм бэ. Томилогдох гэж байгаа хүмүүс нь тодорхой сонгон шалгаруулалт, тодорхой шалгуур давсан. Энэ хүмүүс мэргэжлийн томилгоо, тэр нөгөө жинхэнэ утгаар нь мерит томилгоо явах энэ боломжуудыг л бид нар хангах ёстой гэж ойлгож байгаа юм. Тэгээд яах вэ, Засгийн газар дээр ярилцаж байгаад бас Засгийн газрын гишүүдийн байр суурь өөр байсан учраас өнөөдрийн байгаа хуулийнхаа хүрээнд бид нар ингээд өргөн барьчихсан юм. Ямар ч байсан хэлэлцүүлгийн үед бол Улсын Их Хурлын гишүүдийн өргөн барьсан хувилбарт саналууд байгаа. Ингээд 2-3 хувилбарт саналуудаас бид нар хамгийн зөв хувилбарыг нь сонгоод аваад явах ийм бололцоонууд нь өнөөдөр байгаа л гэж харж байгаа юм.

**Г.Занданшатар:** Одоо Ням-Осорын Учрал гишүүн.

Гонгорын Дамдинням дарга Байнгын хорооны дарга хариулна. Байнгын хороон дээр хэлэлцэгдсэн асуудлуудаар.

**Г.Дамдинням:** Тэмүүлэн гишүүний ярьж байгаа асуудал болбол чухал асуудал аа. Эрхэм гишүүдтэй уулзаад ингээд Байнгын хорооны даргын хувьд уулзаад ярилцах дээр зэрэг орон нутгийн сонгуульд аймаг дээрээ ялагдчихсан гишүүд нь босоо олгоё оо гэдэг. Орон нутгийн сонгуулиар аймаг дээрээ ялчихсан гишүүд нь болохоор зэрэг ингээд хэвтээгээр байж байя аа гээд. Ингээд энэ үндсэндээ тэгээд л нөгөө улс төрчдийн нөлөөллийн асуудал яг одоо ингээд давхар яригдаад л явж байгаа юм. Тэгэхээр бодит байдлыг болбол бид нар харах ёстой. Тэгээд боловсролын ерөнхий хууль, тэгээд ерөнхий боловсролын тухай хууль гээд энэ үндсэндээ энэ багц хууль өргөн баригдах нь тухайн асуудлыг бид нар энэ яамтай нь, засагтай нь ярьж байсан учраас бол хүлээгдээд байгаа юм. Тэгээд энэ том хууль ороод ирлээ. Энэ хуулийнхаа том агуулгын хүрээнд аваад хэлэлцүүлчихье ээ гэдэг ийм байр сууринаас болбол энэ хуулийг одоо Тэмүүлэн гишүүний өргөн барьсан хуулийг бол хойш нь ингээд бариад байж байгаа.

Энэ дээр бол ялангуяа энэ Улсын Их Хурал дээрх намын бүлгүүд дээрээс бас шийдэл гарах ёстой. Үүний дараа болбол энэ асуудлуудыг ярина аа. Ер нь энэ боловсролын багц хуулийн хүрээнд зарчмын шийдлүүд хийх ийм шаардлагатай зүйл заалтуудыг нэгтгэж байгаад дахиад нэг хэлэлцэх тухай асуудал яригдана аа. Тэр үедээ ингээд нэгтгээд ярих тухай асуудал байх юм аа. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Ер нь их, дээд сургууль, сэдэв, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагын томилгоог хараат бус, мэргэжлийн академик болгох чиглэл рүү л явах ёстой л юм байгаа юм л даа.

Ням-Осорын Учрал гишүүн.

**Н.Учрал:** Би Байнгын хороон дээрээ тодорхой асуултуудыг асуусан. Тэгэхээр одоо 1 зүйлийг бас хэлэх ёстой байх гэж бодож байна. Энэ боловсролын хууль дотор тийм дээрэнгүй нэг хэд хэдэн заалт байгаа юм аа. Нэг тийм дээрэлхүү заалтууд. Аюулгүй байдлын мэргэжлээр зөвхөн төрийн өмчийн сургууль, сургалт явуулна аа гээд заачихсан. Нэг ёсондоо болбол жишээ нь Америкт хуулиар харвардын их сургуулийнхаа бизнесийн хөтөлбөрийг улсын сургуулиуд руугаа шууд авдаггүй шүү дээ. Академик эрх чөлөөнд чөлөөт зах зээлийн бүдүүлгээр халдсан энэ заалтууд их олон харагдаж байгаа.

2-т бид нар ер нь хуулиар бүгдийг засдаг болчихлоо. Төрийн захиргааны байгууллагуудын гаргаж байгаа энэ шийдвэрүүдийг хуулиар аргагүйн эрхэнд засаж байна. Дэлхий дахинд энэ их, дээд сургуулиудын ранкийг одоо таймс ай ранкин ч юм уу, шанхай ранкин ч юм уу ранкинг тодорхойлдог. Энэ ранкин дотроос бас одоо вэб оп франкен гэж энэ вейбо метрикс гэдэг энэ вэб хуудсан дахь дэлхийн их дээд сургуулиудын раинг байгаа. Энэ дотор манай нөгөө нэг маргаан дагуулаад байгаа, 1942 онд байгуулагдсан, бидний өв соёл, үнэт зүйлд шингэсэн Монгол Улсын Их сургуулийн нэрийг чинь монголиан начинало университ гэж нэрээр хайгаад үзэхээр тэр дотор чинь нөгөө хувийн сургуулийнх нь үндэсний их сургуулийнх нь нэр гарч ирээд ранк нь өөрчлөгдчихсөн. Нэг ёсондоо болбол яг энэ вейбо метрикс дээр болбол 26337-д үндэсний их сургууль нь байрлаж байгаа юм байна. Ранкаараа. Манай улсын их сургууль нь 3037-д байгаа юм байна. Гэтэл 26337-д оронгуут нөгөө гаднынхан чинь одоо будилаад манай нэрүүдийн хооронд. Манай нөгөө 1942 онд байгуулагдсан улсын сургууль гэж 26000-д ранглж байгаа юм байна аа гээд ойлгоод оронгуут тэр вэб хуудас руу нь яваад орчихдог. Бид нар чинь ер нь хөгөө чирж байна шүү дээ.

Нэг оюуны өмчийн байцаагчийн буруутай шийдвэр, улсын бүртгэлийн байцаагчийн буруутай шийдвэрээс болоод энэ сургуулийнхаа нэр хүндийг ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Учрал гишүүн нэмэлт 1 минут.

**Н.Учрал:** Одоо эргээд 8 жилийн өмнө энэ одоо хувийн сургуульд өгчихсөн нэрээ буцаагаад хуулиар авах гээд байгаа юм уу. Үндэсний, Монгол Улсын гэсэн үгийг зөвхөн төрийн өмчит сургууль хэрэгжүүлнэ ээ гэх юм. Энэ үндэсний их сургууль гэдэг сургуулийг чинь хэдэн мянган оюутан төгсчихсэн шүү дээ. Танай сургуулийн нэр өөрчилчихлөө, хууль гарчихлаа гэх юм уу. Хүнээ боддоггүй. Тэгээд нэг аргаа бараад нэг олон жилийн дараа хуулиар ийм байдлыг хүчээр шийдэж болохгүй ээ. Тэр хувийн сургуулийг чинь төгссөн зөндөө бас төгсөгч нар байгаа шүү дээ. Тэд нарыг яа гэж байгаа юм. Ийм байдлаар хандаж болмооргүй байна.

3 дугаар асуулт. Боловсролын суурь хуульд багшийн хөгжлийг дэмжих тухай хууль хамаагүй юм уу? Өнгөрсөн парламентад батлуулсан миний энэ санаачилсан хууль. Миний энэ хуулийг шоовдорлоод байна уу? Яачхав. Энэ боловсролын хууль нь хамаагүй юм уу, хэдэн зүйл заалтыг нь аваад энэ боловсролын суурь хууль

дээр хийчихсэн л байна. Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийг хэрэглэхгүй юм уу?

**Г.Занданшатар:** Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Дээд боловсролын эрэмбэ, дээд сургуулиудын асуудлуудаар манай Должин дарга, Намнан, Оюунаа зөвлөхүүд бас нэмээд хариултууд өгчхөөрэй гэж бодож байна.

Учрал гишүүн ээ, би энэ багшийн хөгжлийн тухай хуулийг Байнгын хорооны дарга байхдаа та санаачилж би ажлын хэсгийн даргаар нь ажилласан. Ер нь багшийн хөгжлийн бие даасан хуультай улс орнууд их цөөхөн. Бараг гарын арван хуруунд багтах л ийм цөөн улсуудын нэг болсон. Маш их том дэвшил болсон. Ер нь болбол энэ багшийг бэлдэх, багшийг давтан сургах, багшийн цалин урамшуулал, нийгмийн баталгааны асуудлуудыг яг бас энэ хуулиараа бид нар тодорхой баталгаажуулж өгсөн ч гэсэн яг боловсролынхоо ерөнхий хууль дээр бас бид нар ерөнхий хуулиараа дамжиж засаж залруулах ийм зүйлүүд бас байна аа. Учрал гишүүн ээ. Яг ингээд салбар хариуцаад очоод ингээд энэ багш, сурган хүмүүжүүлэгчдийн өмнө тулгамдаж байгаа асуудлууд, энэ боловсролын чанарын асуудлууд, багшийн ажлын гүйцэтгэлийн асуудлууд, багшийн зэрэг дэвийн асуудлууд, өнөөдрийн Багшийн их сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний төв гээд яг энэ боловсролынхоо бодлогыг хийх, энэ чадавхыг бэхжүүлэх, энэ байгууллагуудаа тодорхой чадавхижуулах ийм зайлшгүй өнөөдөр ийм шаардлагууд өнөөдөр үүссэн байгаа. Тийм учраас энэ Багшийн хөгжлийн тухай хууль цаашдаа хүчин төгөлдөр явна аа. Хүчин төгөлдөр явна. Боловсролынхоо ерөнхий хуулийн нэг хэсэг болоод ингээд хүчин төгөлдөр болоод явна аа. Энэ дээр ерөөсөө санаа зоволт байхгүй.

2-т бол бид нар энэ их, дээд сургууль дээрээ одоо жаахан эрэмбэ тавья аа. Одоо ингээд дураар нь тонгочуулаад. Ингээд өнөөдөр яг юу болсон гэдгийг бид нар өнөөдөр ямар хэмжээнд хүрчхээд байгаа гэдгийг бид нар ойлгож байна шүү дээ. 147 мянган хүүхдийн хувь заяагаар тоглож байгаа ийм сургуулиуд өнөөдөр байна шүү дээ. Өнөөдөр Монгол Улсад 3361 хөтөлбөр байдаг юм байна лээ. 3361 хөтөлбөр. Үүнээс өнөөдөр яг магадлан итгэмжлэлд үлдсэн хүчинтэй байгаа хөтөлбөр нь зуун тавь жархан хөтөлбөр л сууж байна шүү дээ. Ингэж болох юм уу? Өнөөдөр зөвхөн нэг сайдын үзэгний үзүүрээр дээд сургууль ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Наянтайн Ганибал гишүүн.

**Н.Ганибал:** Боловсролын хууль чухал хууль аа. Тэгээд нэлээдгүй судаллаа. Яах вэ, Боловсролын ерөнхий хуулийн төслийн харах юм бол одоо үр дүнд суурилсан аргыг нэлээн сайн ашиглаад дэд салбар бүрд тулгарч буй саад бэрхшээлүүдийг бол бүлэглэн томъёолсон байна.

Үүнийхээ үндсэн дээр болон олон улсын түвшний чиг хандлага дээр суурилад салбарын одоо мэргэжлийн хүмүүс нь зорилго, зорилтууд болон хүрэх үр дүнгээ хэмжиж болохуйцаар сайн тодорхойлсон гэж найдаж байгаа юм. Тэгэхдээ энэ дотор бол бас анхаарал хандуулах нэлээдгүй асуудлууд байна аа. Тэгээд 3 асуулт байна.

Энэ заавал эзэмших боловсролыг 9 жилийн суурь боловсролд байгааг 12 жилийн боловсрол болгохоор тусгасан байна. Тэгэхээр боловсролын талаарх энэ

тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд бол сургуулийн өмнөх боловсролыг болбол 1 жилийг заавал эзэмших боловсрол болгохыг онцолсноос биш яг энэ бүрэн дунд боловсролыг заавал эзэмших ёстой гэж заагаагүй. Манай улсын хувьд бол 2019 оны байдлаар бүрэн дунд боловсролын хамран сургалтын цэвэр жин тийм ээ, одоо хамрагдаж байгаа жин нь бол 86,5, харин төгсөлт нь 70,5 байгаа юм. Тэгэхээр энэ одоо шинэ хуулиар эдгээр хувиудыг 100 хувь болгоно оо гэсэн ийм зорилтыг тавьж байгаа юм байна. Үүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилт, боловсон хүчин, дэд бүтэц, одоо багшийн нийлүүлэлт гээд ингээд олон асуудлууд байгаа. Энэ одоо тэгэхээр суурь боловсролоо бид нар дүүргээд буюу 9 дүгээр ангиа төгсөөд хөдөө аж ахуй, мал аж ахуй дээр гарч байгаа. Мөн МСҮТ-д суралцах хүүхдүүдийн асуудлыг энэ дээр хэрхэн авч үзэх юм бэ?

2 дахь асуудал. Сургалтын чанарт суурилсан багшийн цалин урамшууллыг олгох тухай шинэ заалтуудыг оруулсан байна. Үүнийг ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Нэмэлт 1 минут.

**Н.Ганибал:** Тэгэж та бүхэн бас сайн үзээрэй. Ер нь багш нарын цалингийн асуудал дээр бол сурлагын амжилтаар нь дүгнээд боловсролын чанар, тэгш байдал, тэгш боломжийг хангахад тулгарч буй асуудлууд чинь илүү ингээд гаарна тийм ээ. Тэгэхээр энэ дээр бас та бүхэн маш сайн судалсан тэр юугаа эргэж харах ёстой юм байна. Ер нь бид нар Юнеско гаргасан судалгаанаас 2015 онд боловсролын нийт зардал эзлэх багшийн цалингийн хувь бол 42,6 байснаа одоо 2019 онд буурсаар байгаад 30,4 болчихсон юм байна. Тэгэхээр энэ дээр бас бодох хэрэгтэй байна.

3 дахь асуудал бол санхүүжилтийн асуудал байгаа. Санхүүжилт дээр манай одоо сүүлийн 5 жилд дотоодын нийт бүтээгдэхүүний боловсролд зарцуулсан 4,4, улсын төсөв болохоороо 14,2 байгаа. Тэгэхдээ энэ маань ингээд буураад байна. Тэгэхээр энэ дээр яг санхүүжилтийг хэрхэн зөв томьёолох, тэрийгээ хяналтад ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд асуултад хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Бид нар энэ заавал эзэмших боловсролыг 12 жил болгоход нь бараг үндэсний аюулгүй байдлын асуудал гэж би бодож байгаа юм. Өнөөдөр бид нар энэ 2 том гүрний дунд хэдэн хүн амтай гүрний дунд байгаа билээ. Тэгээд 3,2 сая хүн амтай. Ийм улс бид нар одоо иргэдээ хамгийн чадварлаг мэдлэгтэй болгох чиглэл рүү л бид нар анхаарах ёстой. Ажилчин анги бэлдэнэ гэдэг нэг энэ тогтолцооноосоо бид нар ер нь салмаар байна аа. Ганибал гишүүн ээ, та хүүхдээ 9 дүгээр ангиас нь та МСҮТ рүү явуулах уу. Одоо яг өөрийнхөө хүүхдийг. Та надад нэг хэл дээ. Би явуулна аа гэж. Өнөөдөр энэ 9 дүгээр анги төгсөөд 8-10 мянган хүүхэд МСҮТ рүү орж байгаа юм байна. Тэгээд 2,5 жил сурдаг. Ерөнхий боловсролынхоо одоо бүрэн дундынхаа боловсролынхоо үзэх ёстой 100 хувийн хичээлийн 40 хувийг үздэг. Ингээд ерөнхий боловсролын боловсрол ч байхгүй, мэргэжлийн боловсролынхоо үзэх ёстой хичээлийн 100 хувь гэж үзвэл 50 хувийг нь үздэг. Ингээд нэг ийм хагас дутуу боловсролтой. Тэгээд 2,5 жил сурчхаад дахиад гараад ажлын зах зээл дээр хөдөлмөрийн зах зээл дээр гараад 6 сар хүлээдэг. Яагаад гэвэл 18 нас хүрдэггүй. 18 нас хүрдэггүй. Тийм учраас бид нар ингээд энэ 9 дүгээр ангиас нь 8-10 мянган хүүхдийн хувь заяаг ингээд өөрт нь даатгаад ингэж хаяж болохгүй улс орон байхгүй юу. Болохгүй улс орон. Бид нар ер нь суурь боловсрол 10, 11, 12 дугаар ангид нь МСҮТ-ийг дагасан төрөлжсөн ахлах

сургуулиуд, коллежуудыг дагасан төрөлжсөн ахлах сургуулиуд, их, дээд сургуулиудыг дагасан төрөлжсөн ахлах сургуулиудыг бид нар байгуулж байж л арай нэг жаахан чадвартай, мэдлэгтэй ийм залуучуудыг л бид нар бий болгох ёстой юм байна лээ. Одоо бид нар малчин хүн ч гэсэн өнөөдөр менежерийн сургалтын боловсрол олж суурь боловсрол болж энэ 12 жилээр төгсөж МСҮТ-ийг заавал ч үгүй 2,5 жил биш, 12 жил төгссөн хүүхэд болбол ахлах сургуулиараа дамжаад сурсан бол 3-6 сар одоо хамгийн ихдээ удаан хугацаанд болбол 1 жил сураад ингээд ээлжийн ахлагчийн мэргэжлийн үнэмлэхээ аваад ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Тогмидын Доржханд гишүүн.

**Т.Доржханд:** Баярлалаа. 1 минутаа нэмээд авчихъя.

Боловсролын шинэчлэл бол хийх нь зүйтэй. Тэгээд хэлэлцэх эсэх асуудлыг бол дэмжиж байна аа. Гэхдээ маш олон нөгөө мэргэжилтнүүдийн бас байр суурь хэрэгтэй байх. Тэгээд над дээр бол бас нэлээн олон саналууд бол бас байна. Тийм болохоор энэ чуулган хаахаас өмнө хэлэлцэх эсэхээ шийдчихээд, тэгээд дараа нь бол мэргэжлийн байгууллагууд болон холбогдох мэргэжилтэн, судлаачуудаасаа саналаа авах юм байгаа биз дээ. Энэ дээр сайд нь тодорхой хариулаад өгчхөөрэй.

2 дугаарт, энэ агуулгаас ярихаасаа өмнө бид нарын бас тооцооллоор бол хамгийн болохгүй байгаа асуудал бол ерөөсөө л багшийн цалин байна аа гэж. Багшийн цалин чинь өөрөө дундаж цалингаасаа 30-40 хувь бага байна шүү дээ. Үүнтэй холбоотойгоор яаж сайн багш байх вэ дээ. Тэгээд цалингийн асуудлыг ядаж дундаж руу ойртуулах чиглэлээр яг ямар арга хэмжээг авахаар энэ хуулийн зохицуулалт бол байгаа юм бэ. Энэ дээр бас тодорхой хариулт авмаар байна.

Дараагийнх нь энэ ахлах сургуулийг төрөлжүүлэх асуудал хэрхэн туссан бэ гэж. Одоо ингээд заавал их сургуульд орж байгаад мэргэжлээ сонгоод явах юм уу? Эсвэл наад тал нь төрөлжүүлээд яах юм уу? Одоо Монгол чинь бол эдийн засгийн онцлог нь өөр шүү дээ. Тэгээд уул уурхайгаас хамаарсан уул уурхайгаас хамаарсан хөгжиж байгаа эдийн засгуудаас хамгийн сайн явж байгаа нь Чили байгаа. Гэтэл Чилид уул уурхайн экспорт яг манайхтай адилхан 60, 70 хувьтай уул уурхай нь хийдэг боловч яг ажлын байр нь болохоор 4-хөн хувь байгаа. Уул уурхайн салбар нь. Маш олон дипломтой ажилгүйчүүд, тэгээд хүмүүсээ нэг мэргэжилтэй мэдлэгтэй болгоё гээд байдаг. Гэтэл эдийн засгийнх нь нөгөө хэрэгцээ нь өөр байгаад байдаг. Яг үүний араас Монголд яваад байгаа байхгүй юу. Тэгээд үүнтэй холбоотойгоор хуулийн төсөл дээр ямар зохицуулалт орсон юм бэ?

Боловсрол сонголттой байх зарчим хэд болсон бэ? Хувийн болон төрийн сургуулиуд дээрээс нь танхим болон цахимаар хосолсон хэлбэрээр Монгол чинь бол ингээд том газар нутагтай. Тэгээд урсгал зардал маш их өндөр байдаг. Тэгээд хамгийн сайн математикийн багш, хамгийн сайн англи хэлний багшийг, тухайлбал Ховдод, тухайлбал Дорнодод байгаа тэр сургуульд нь ингээд цахимаар орох бүрэн боломж нь бол байгаа шүү дээ. Тийм яг энэ давуу талаа яаж ашиглаж, яаж энэ зохицуулалтаа хийх юм бэ гээд.

Тэгээд эцэст нь бол мэдээж багш нарын л асуудал эргээд л яригдана. Тэгэхээр нөгөө чадвартай багшаа бэлдэнэ ээ гэдэг яг дэвшилттэй ямар зохицуулалтыг та нар маань оруулаад ирэв ээ? Энэ багийг нь харахад бол боломжийн л баг харагдаад байх шиг байна. Тэгээд яг багш гэдэг чинь бол үндсэн

цөм нь байна аа. Тийм болохоор энэ хүмүүсийг бэлдэж боловсруулахад санхүүгийн хөшүүрэг, дээрээс нь мэдлэг мэдээллийн хөшүүрэг. Гадаадад сурч ирсэн багш нарыг тухайлбал ямар хөнгөлөлттэй нөхцөлөөр шууд ажилд нь орох уу. Түрүүчийн яриад байгаа энэ нөгөө улс төрөөс хамааралгүй байх байдлыг яаж хийх вэ? Хоёр... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд асуултад хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Энэ боловсролын хууль бол энэ үндэсний зөвшилцлөөр одоо гаргах ёстой хуулиа. Аль нэг намын өмчлөх ёстой хууль биш. Тэр Ардын намын боловсролын хууль, Ардчилсан намын боловсролын хууль, Хүн намын боловсролын хууль гэж ерөөсөө байж болохгүй. Тэгэхээр аль болохоор бид нар үндэсний зөвшилцөл хийх энэ хэмжээнд л бид нар одоо ажлын хэсгүүд ажилласан. Манай нэг ажлын хэсгийг бол Хүн намын Наранбаяр 1 ажлын хэсгийг нь ахалж ажилласан. 8 ажлын хэсэг. Өнөөдөр боловсролын шинэчлэл, реформын талаар ажилладаг эрдэмтэд, судлаачид бүгд орж байгаад 8 ажлын хэсэг ажиллаж өнөөдөр ингээд энэ ажлын тайлангаа бид нар та нарт ном болгож хүргүүлсэн байгаа юм. Ажлын тайлан. Энэ тайлан дээр гарсан зөвлөмжүүд дээр үндэслэж л бид нар энэ боловсролынхоо салбарын реформуудын гол зарчмуудыг энэ хуульдаа тусгасан юм байгаа. Тийм учраас бид нар одоо тодорхой хэмжээнд болбол үндэсний зөвшилцлийн хүрээнд энэ хэлэлцүүлэг хийсэн.

Би өчигдөр Ардчилсан намын бүлэг дээр орж энэ өргөн барьж байгаа хуулийнхаа төсөл, концепцыг бас танилцуулсан. Аль болохоор л одоо улс төрийн бүх хүчний оролцоог оруулж байж бид нар ингэж энэ боловсролынхоо реформ шинэчлэлүүдийг хийх ийм зарчмыг барьсан шүү, Доржханд гишүүн ээ.

2 дугаар асуудал болбол энэ ахлах сургуулийг төрөлжсөн байх энэ Наранбаярын л одоо саналдаа. Галбаатар багш энэ тэрийн санал. Тийм учраас манай одоо бид нар 12 жилийн тогтолцоонд нэгэнт шилжүүлж байгаа учраас 10, 11, 12 дугаар ангийн төрөлжсөн сургуулиудыг бид нар ерөөсөө энэ коллежоо дагуулаад их, дээд сургуулиудаа дагуулаад энэ лицей сургуулиудыг байгуулах магадгүй хөдөө аж ахуйн чиглэлээр. Ахлах сургуулиуд. Магадгүй хөнгөн үйлдвэрлэлийн чиглэлээр ахлах сургуулиуд. Урлагийн чиглэлээр соёл урлагийн чиглэлээр ахлах сургуулиуд гэх мэтчилэнгээр, ингээд коллеж, их, дээд сургуулиудаа дагасан ийм ахлах сургуулийн тогтолцоог одоо бий болгоно оо гэдэг ийм зүйлүүдийг орсон байгаа.

Хамгийн гол асуудал бол ерөөсөө л энэ багш нарын цалин хөлс, урамшууллын асуудал юм байгаа юм. Тийм учраас энэ чадварлаг багш гэдэг хөтөлбөрийн хүрээнд бид нар үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо руу шилжинэ. ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Ер нь Байнгын хороон дээр Дамдинням дарга ч хэлнэ лээ. Үүнийг бол зунжин, намаржин сайн хэлэлцүүлэг, багш нараар, сурагч нараар бүх оролцогч нараасаа хэлэлцүүлэг явуулж хангалттай л ярина л даа. Угаасаа 2 минутад ч бай, 20 минутад ч бай өнөөдөр бүх ойлголтыг энэ нарийн тогтолцоо бүгдийг нь ойлгоод мэдчихнэ ч гэж байхгүй байх.

Норовын Алтанхуяг. Нэмэлт 1 минут бол тодруулж болно.

Тогмидын Доржханд гишүүн 1 минут.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр нөгөө одоо ингээд сайхан хууль бол хийж болж байна аа. Тэгээд реформ хийх нь бол зүйтэй байх. Тэгээд дэвшилттэй байдлаар л бид нар энэ салбараа ингээд босгож ирнэ шүү дээ. Тэгээд гол бодлого чинь бол нөгөө хүндээ байх ёстой. Гол бодлого нь хүндээ. Хүн гэдэг нь өөрөө багш нар. Тэгэхээр бодлогын төв нь бол цөм нь бол багш нар байх ёстой л гээд. Тийм болохоор яг энэ дэвшилтдээ багш нарыгаа чадваржуулах, багш нарынхаа санхүүг нь яг бодитойгоор ингээд дээшлүүлэх, сайн багш нар нь сургуулиа төгсөөд багш болъё оо гэдэг. Тэр хүсэл эрмэлзлийг яаж бий болгох вэ, яг энэ хөшүүрэг нь юу байна вэ гэдэг дээр л товч тодорхой хариулт авчихмаар байх юм. Ингэж байж л бид нарын үр хүүхэд чинь сайн багш нар хичээл заана шүү дээ. Тэгэхгүй одоо болтол ингээд зааж байгаа багш нар чинь цалингаа голоод ямар байгааг бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ.

Дараагийнх нь болохоор хотын төвийн багш, гэр хорооллын хүүхдийн чанарын ялгааг багш нарын ялгааг яаж байхгүй болгох вэ? Сэлгэж заалгах тийм зохицуулалт бол байна уу.

**Г.Занданшатар:** Лувсанцэрэнгийн Энх-Амгаланг сайд.

**Л.Энх-Амгалан:** Доржханд гишүүн ээ, ер нь энэ боловсролын гол реформ бол багшлах уу, суралцах уу л гэдэг. Энэ зарчим дээр явах ёстой юм байна лээ. Тийм учраас энэ багшлах уу гэдэг энэ зарчмыг энэ концепцыг яг амилуулах илүү хүүхдэд, нөгөө урд нь самбарын урд гаргаад ингээд нэг цээжлүүлдэг заадаг. Нэг энэ тогтолцооноосоо биш илүү хүүхдүүдийг өөрийг нь сургах, тэр сурагч төвтэй энэ тогтолцоо руу залах улсууд нь энэ багш нар аа. Тийм учраас ер нь чадварлаг залуучууд, багш болж байж л бид нар үр дүн шаардана. Тийм учраас хамгийн гол логик болбол ерөөсөө багшийн ажлын цалин хөлс, энэ үнэлэмжийг л бид нар тодорхой түвшинд, ядахдаа бид нар хуульчийнхаа цалинг бид нар чинь одоо 3 сая төгрөг болгочхоод байгаа шүү дээ. Хуульчийнхаа цалинг. Тэгэхээр дор хаяж багш нарын цалин 1,5 сая төгрөг ба түүнээс дээшээ байж байж л одоо энэ чадварлаг хүүхдүүд, багш болох энэ сонирхол нь бий болох болов уу л гэж бодож байгаа юм. Өнөөдөр энэ багшийн их сургуульд сурч байгаа, тэр тусмаа сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролоор сурах энэ хүүхдүүд чинь өнөөдөр ийм сонирхолгүй болчихоод байна шүү дээ. Бид нар ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Норовын Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Энэ надад эхлээд 2 горимын санал байна. Занданшатар дарга аа. Энэ ковидын горимоор боловсролын ерөнхий хуулийн төсөл, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хууль гэсэн 3 хуулийг ковидын горимоор яримааргүй л байна. Яах вэ, одоо хэлэлцэх эсэхээ шийдчихээд. Тэгээд намар бол хэдүүлээ жаахан зөв горимоор яримаар байна. Хоёрын хооронд 2 минут, ингээд 3 хууль нийлүүлээд ярихаар чинь одоо асуусан ч болохгүй сэглээд сэглээд хаяж байна. Сая бүлэг дээр өчигдөр ярихад бас л сэглээд хаясан шүү дээ энэ чинь. Яаж энд 3 хуулийг нэг нь дээд боловсрол, нэг нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, нөгөөдөх нь боловсролын нөхөн хууль байхгүй юу. Үгүй ээ, яах вэ, та судалгааны их сургууль, эрх зүйн байдлын тухай хуулийг дээд боловсрол руу оруулаад ярьчихъя гэсэн шүү дээ.

Ингээд гурав пактически гурван хууль байгаа юм. 1 дүгээр санал шүү.

2 дугаарт нь энэ 3 хуулийг салгаж ярья аа. Дээд боловсролын тухай хууль шал өөр юм байхгүй юу. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол дахиад тусдаа. Ерөнхий хууль чинь тустай. Ингэвэл ядаж 2, 2 минут, одоо бүр бүр ковидороо гүйсэн чинь 2, 2, 3, 6 минут байхгүй юу. Ингэж байж бид нар үүнийг сайн ярина. Яагаад энийг сайн ярих ёстой вэ гэхээр үнэхээр бид нарын хүүхдүүдийн маргаашийн хувь заяа, Монголын хувь заяа чинь энэ хуулиар шийдэгдэнэ. Өнөөдөр бид нар буруу явчихсан шүү дээ. Тэгээд л их олон асуудал дотогшоо орохоор их олон маргаантай асуудал үүснэ. Тэгэхдээ би ерөнхийдөө мэдлэг чадвар, хандлага дээр суурилна аа гэдэг их зөв зарчим гарч ирсэн байна аа гэж харж байгаа. Зүгээр 1-9 дүгээр анги уу, 1-12 дугаар ангиу. Өчигдөр бас Энх-Амгалан сайдад хэлсэн. Миний бодлоор бол би түрүүн Оюунчимэг гишүүний хэлж байгаатай ойролцоо л байгаа юм. Тэгэхээр арван мянган хүүхдээ ингэчихлээ бүгдээрээ арван хоёр төгсөх ёстой юм гээд маргаж байна л дээ. Тэрийг нэг явцын дунд ярья.

Ер нь энэ Монгол хүүхдүүдээ Монгол хэл, соёлд тэгээд чадвартай, тэгээд хандлага нь зөв байх гэдэг дээрээ нэлээн акцент өгч ярих ёстой. Скүүл майфин гээд ийм англи үг яриад байна лээ. Одоо би бас бодоод байгаа юм. Энэ ер нь хөдөөний сум ингээд 12 жилтэй болчихлоо гээд л баярлаад байгаа юм. Би бол тэр хөдөөний сумын хүүхдийг алж байна гэж харж байгаа юм. Тэр нэг бүлэг дээр математикийн, физикийн, биологийн, химийн тийм боломжтой багш тэр цалин дээр тэнд тэгж хэдхэн хүүхдийн өмнө зогсоно гэж байхгүй. Энэ хувийн их, дээд сургууль ч гэсэн бас энэ агуулгаараа бас бодох хэрэгтэй. 100 оюутны өмнө зогсдог багш, 1000 оюутны өмнө зогсдог багш, тэрний ашигт үйлийн коэффициент, тэр багшид очдог цалин гээд их олон юм их өөр байдаг юм. Тэгэхээр та нар энэ одоо юу гэдэг юм бэ дээ. Энэ дээр үед болбол нэг сумдын дунд нэг 10 жил байсан шүү дээ. Тэгээд тэр нь жаахан томхон суман дээрээ төвлөрөөд тэр дээр нь одоо тэр нарийн мэргэжлийн багш нар нь тэр лабораторид байна уу, юу байна вэ, янз янзын ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Дамдинням дарга хариулъя. Байнгын хороо. Сайд хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Би Алтанхуяг гишүүнтэй ер нь санал нэгтэй байгаа юм аа. Боловсролын хуулийг ковидын хуулийн зарчмаар горимоор ярина гэдэг их хэцүү л дээ. Тэгэхдээ яах вэ, энэ ямар ч байсан энэ бол хэлэлцэх хэсэг нь юм. Алтанхуяг гишүүн ээ. Тийм учраас одоо энэ удаагийн чуулганаар бол бид нар хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, зунжингаа хэлэлцүүлэг хийх хангалттай боломж, хугацаа гарах болов уу гэж бодож байгаа юм.

Ингээд Байнгын хороон дээр болбол энэ 3 хуулиараа дагнасан ажлын хэсэг гарах юм байна лээ. Боловсролын ерөнхий хууль, ерөнхий боловсролын хууль, их дээд сургуулийн хууль. Тийм учраас Алтанхуяг гишүүн энэ хуулиуд дээр яг аль чиглэлийн, аль түвшний, одоо боловсролынх нь салбарын реформын өөрчлөлт, бодлогын өөрчлөлтүүдэд оролцох хүсэлтэй байгаа. Энэ чиглэлд байгаа ажлын хэсэгт ороод ажиллах нь бол бас би нээлттэй болов уу гэж бодож байна.

Тэгээд Алтанхуяг гишүүний яриад байгаа үндсэндээ бол сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилго болбол бид нар суралцагчийг бие даан сурч амьдрахад шаардагдах суурь мэдлэг чадварыг хөгжүүлж, ёс зүйтэй, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэн болгож төлөвшүүлэхэд л энэ хуулийн зорилго оршино гэж байгаа юм. Тийм учраас бид нар цаашдаа энэ

дэлхий нийт 21 дүгээр зууны чиг хандлага, мөн Монгол Улсын зөв Монгол хүнийг бий болгох хөгжлийн хэрэгцээ шаардлага болбол мэдлэг чадвар, төлөвшил гэсэн энэ цогц чадамжийг эзэмшүүлэх. Бид нар ийм л түвшний боловсролыг олгох ёстой юм байна лээ. Энэ дээр бол би тантай санал нэг байна.

Нөгөө талаасаа бол одоо бид нар энэ хөрөнгө оруулалтын бодлого дээрээ бид нар жаахан өөр газар зүйн мэдээллийн систем дээр үндэслэсэн тухайн суманд яг хэдэн хүүхдийн цэцэрлэг, хэдэн хүүхдийн сургууль хэрэгцээ шаардлагатай юм бэ гэдгээ ингэж зөв төлөвлөдөг л ийм тогтолцоо руу бид нар шилжих ёстой. Өнөөдөр Их Хурлын танхимд Их Хурлын гишүүн сумандаа хэдэн хүүхдийн цэцэрлэг, хэдэн хүүхдийн сургууль барихыг ингээд шийдээд байж болохгүй. Тэр тусмаа өнөөдөр зураггүй, төсөлгүй, газаргүй шийдэгдсэн асуудлаас болж энэ хөрөнгө оруулалтууд хойшилж байгаа ийм гашуун туршлагауд бид нарын дунд байна аа. Тэгэхээр цаашдаа бид нар энэ сургуулийн бүтэц, байршил, хэв шинжийг оновчтой болгох энэ хувилбаруудыг бид нар эдийн засгийн тооцоо судалгаан дээрээ одоо тулгуурлан ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг гишүүн.

**С.Чинзориг:** Хэдэн асуулт байна аа, Энх-Амгалан сайд аа. Цэцэрлэгийн хүүхдийн насыг 2-5 байгааг, 3-5 болгож байгаа юм байна. Энэ ямар үндэслэл, хэрэгцээ шаардлага байгаад ингээд 3-5 удаа олгож байгаа юм бэ?

2 дугаарт ерөнхий боловсролын сургуулийг ерөнхий боловсролын болбол боловсрол болбол 12 жил байх нь л дээ. Ер нь бол сая Алтанхуяг гишүүн ч яриад, ер нь 12 жил хүүхэд болгоныг 12 жилийн боловсрол эзэмшүүлнэ гэх үү, зөв үү? Хэрвээ ингээд жил болгоно гэвэл одоогийн байгаа нөгөө мэргэжлийн боловсролынхоо сургалтын тогтолцоог эвдэх нь л дээ. Энэ Засгийн газар чинь энэ халамжаас хөдөлмөрт гээд л баахан юм яриад байх юм. Агаараар яриад нисээд байдаг. Тэгээд одоо хөрсөн дээрээ буугаад ажлаа хиймээр байх юм. Гэтэл одоо юу нөгөө халамжаас хөдөлмөрт гэж одоогийн байгаа мэргэжлийн боловсролынхоо тогтолцоог эвдэх нь л дээ. Тэд энэ бас хэр одоо зөв оновчтой юм бэ гэж.

Багш нарын нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр хуульд ямар шинэлэг юм орж байгаа юм бэ? Би зүгээр өнөөдөр хуулийн төслийг авсан, гүйлгээд харсан тийм нэг онцлог шинээр гэхээр одоо юм бол байгаа л юм шиг байгаа юм. Тэр гүйцэтгэлээр нь, үр дүнгээр нь гэсэн нэг өгүүлбэр орж ирж байгаа юм.

Их, дээд сургуулиудын сургалтын төлбөрийг ер нь цаашдаа тогтвортой байх өсөхгүй байлгах тийм тогтолцоо бид нар эрж, хайж чадах уу, үгүй юу. Одоо хөдөөгийн иргэдийг ядууралд оруулж байгаа юм чинь ерөөсөө сургалтын төлбөр байна шүү дээ. Хувийн сургуулиуд дүүрчээ. Төрийн мэдлийн их, дээд сургуулиуд чинь үйл ажиллагааныхаа зардлын 90-95 хувийг зөвхөн сургалтын төлбөрөөрөө санхүүжүүлдэг ийм тогтолцоо байна шүү дээ. Энэ тогтолцоотойгоо ингээд цаашаа одоо бид яваад байх уу? Судалгааны их сургууль гэж асуудал оруулж ирэх юм аа. Энэ одоо хэрэг байгаа юм уу? Энэ тусдаа хууль байх хэрэг байна уу? Тусдаа сургууль байх хэрэг байна уу? Их, дээд сургуулиуд чинь бүгдээрээ л эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага шүү дээ. Тэгээд тусдаа хуультай, тусдаа сургуультай болох ийм шаардлага байгаа юм уу гэсэн ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Чинзориг гишүүний их, дээд сургуулиудын тэр төлбөрийн асуудлаар Должин дарга нэмж хариулт өгөөрэй.

Энэ багш нарын нийгмийн баталгааны асуудлууд яаж туссан, ямар дэвшил, одоогийн байгаагаасаа ямар дэвшил гарч байгаа гэдгийг Ням-Очир дарга хариулах ёстой байх.

Тэр 2 насыг 3 нас болгосон асуудал дээр Мягмар дарга илүү дэлгэрэнгүй бас хариулт өгчхөөрэй.

Энэ болбол том, одоо хуулийн том зарчмын асуудал учраас энэ 12 нас, 3-5 нас дээр би бас нэг тодорхой тодруулга өгчихье өө гэж бодож байна. Бид нар, ер нь дэлхийн улс орнууд сургуулийн өмнөх боловсролын насыг ер нь 3-5 нас л гэж авч явдаг юм байна. 3-5 нас. 0-2 нас бол хүүхдийн хөгжлийн алтан үе гэж байдаг юм байна, алтан үе гэж байдаг. Тийм учраас энэ дээр эцэг эхчүүдийн оролцоо, энэ бол нийгмийн хамгааллын асуудал. Энэ бол эрүүл мэндийн асуудал, хүүхдийн хөгжлийн асуудал. Тодорхой хэмжээнд боловсролын асуудал байгаа. Тэгэхээр бид нар цаашдаа энэ Монголын хувьд ийм том сорилт үүсээд байгаа юм л даа. 2 настай хүүхдүүдийг цэцэрлэгт бүрэн хамрагдах уу? Хамрагдах нь одоо Монгол Улсын хэмжээнд өнөөдөр тулгамдсан асуудал уу, эсвэл сургуулийн өмнөх боловсрол буюу 5 настай хүүхдээ бид нар цэцэрлэгт 100 хувь хамруулах уу гэдэг ийм л 2 сонголт дээр бид нар тулж ирчхээд байгаа юм. Тэгэхээр одоо байгаа бид нар 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсрол гээд заавал хамруулах ийм юутай учраас болбол өнөөдөр ямар нөхцөл байдал байна вэ гэхээр сургуульд орох гэж байгаа хүүхдүүдийг чинь бараг үндсэндээ 20-30 хувь нь энэ сургуулийн 5 настай хүүхдийнхээ цэцэрлэгт хамрагдаж чадахгүй. Ингэснээр гарааны тэгш бус байдал үүсэж байгаа юм. Нэгдүгээр ангиасаа эхлээд үндсэндээ сурлагын хоцрогдол үүсэж байгаа байхгүй юу. Тэгэхээр Монгол Улсын одоо яг өнөөдөр тулгамдсан асуудлын ач холбогдлын эрэмбэ дарааллаар нь эрэмбэлэх юм болбол бид нар 5 настай хүүхдээ сургуулийн өмнөх боловсролын 5 настайд нь 100 хувь хамрагдах ийм зорилтуудыг л хэрэгжүүлэх ёстой гэж ойлгож байна.

2 насан дээр бид нар олон сонголтууд бий болгоно оо. Яслъ нь байна, хүүхэд харах үйлчилгээ нь байна, өдөр өнжүүлэх үйлчилгээ нь байна. Энэ 2 настай хүүхдийн хувьсах зардал гэж байдаг учраас нэгдүгээрт хувьсах зардал, хоёрдугаарт цалинтай ээжийн зардал, гуравдугаарт хүүхдийн мөнгөн дээр тулгуурлахад болбол 300-аас ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Чинзориг гишүүн ээ. Энэ 12 жилийн тогтолцоо нь заавал эзэмших тогтолцоонд боловсролын тогтолцоонд шилжсэнээр мэргэжлийн боловсролыг бид нар улам боловсронгуй болгоно оо. Мэргэжлийн боловсролыг бид нар ерөөсөө эвдэх, сүйтгэх тухай асуудал биш. Харин 2012 онд Боловсролын яамнаас мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв буюу коллежууд ингээд энэ мэргэжлийн болон мэргэжлийн боловсролын энэ тогтолцоог боловсролын тогтолцооноос гаргаснаараа бол маш том эвдрэл гажуудлууд үүссэн шүү. Гажуудлууд үүссэн. Та ингээд энэ хийсэн гажуудлуудыг өнөөдөр зөвтгөөд сууж байж болохгүй. Би таныг ойлгож байна. Салбарын сайд байсныг чинь хувьд ойлгож байна. Гэлээ гэхдээ бид нар өнөөдөр Монголынхоо ирээдүйг зөв харах ёстой. Бид нар хэчнээн ч буруу юмыг засаж залруулах, зөв болгож залахад маш их цаг хугацаа зарцуулах юм байна. Өчигдөр өдөр Ардчилсан намын бүлгийн хурал

дээр Алтанхуяг сайд ч гэсэн Ерөнхий сайд ч гэсэн эргэлзээд сууж байгаа юм байна лээ шүү дээ. Энэ шийдвэр гаргасан шийдвэр маань зөв үү, буруу юу гэдгийг. Тийм учраас өнөөдөр бид нар энэ хэлэлцүүлгийн үед энэ 12 жилийн тогтолцоонд шилжих нь өнөөдөр Монгол Улсын эрх ашгийн хувьд ямар эрх ашиг юм бэ гэдгийг бид нар эрэмбэлэх ёстой юм байна лээ. Бид нар үр хүүхдүүдээ, ер нь 9 дүгээр ангид суурь боловсрол эзэмшүүлээд өөрийнхөө үр хүүхдүүдийг төгсгөхгүй шүү. Өөрсдийнхөө хүүхдүүдийг бол бид нар өндөр төлбөртэй сургуульд англи хэлний төлбөртэй сургуульд сургачхаад хүүхдүүдийг англи хэл зааж болохгүй. Есдүгээр ангиас нь гаргаж ажилчин анги бэлтгэ гэдэг ийм ялгаварлан гадуурхал байж болохгүй ээ. Энэ бол би Монгол Улсын хувь заяаны улс асуудал. Монгол Улсын аюулгүй байдлын асуудал гэж ойлгож байгаа шүү. Чинзориг сайд аа. Харин 12 жилийн тогтолцоонд шилжсэнээрээ Монголын мэргэжлийн боловсролын өнөөдөр гажуудлыг арилгах, засах залруулах маш том түүхэн боломжууд бид нарт олдож байгаа гэж харж байгаа.

**Г.Занданшатар:** 85. Содномын Должин Содномын Чинзориг гишүүнд хариулт өгнө.

**С.Должин:** Эхлээд багшийн нийгмийн баталгааны тухай нэмж тайлбар хийе. Багшийн нийгмийн баталгааны агуулгын хувьд нэлээн том өөрчлөлтийг хийсэн. Хуучин дээд боловсролын хуулийн 14 дүгээр зүйл заалт дээр зөвхөн багшийн хөгжлийг дэмжинэ гэсэн ерөнхий заалт байсан болбол өнөөдрийн бид нарын оруулж ирж байгаа төсөл дээр л 2 том өөрчлөлтийг болбол оруулсан.

1 дүгээрт, өөрийн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнд байгуулсан гарааны компани инновацын бүтээгдэхүүнийг ноогдол ашгийг хүртэх эрхийг багш судлаачид олгож өгсөн.

2 дугаарт, багш ажлын нийгмийн баталгааг хангах, дэмжих үзүүлэх харилцааг бүрэлдэхүүн сургуулийн дотоод журмаар зохицуулах хоёр том заалтыг болбол бид нар оруулаад багшийн нийгмийн баталгаа гэсэн бүр тусдаа 18 дугаар зүйл заалтыг ерөнхий боловсролын хууль дээр оруулж баталгаажуулсан шинэлэг зохицуулалт бас болсон.

2 дугаар асуулт, судалгааны их сургуулийг ёс зүйн бие даасан хуулийг яагаад боловсруулсан бэ, бие дааж орж ирж байна уу гэсэн асуултад хариулъя. Энэ дээр бол 3 үндэслэл байна аа. Нэгдүгээрт бол 2017 оны 295 дугаар тогтоол, 2018 оны Засгийн газрын 218 дугаар тогтоол, мөн дээд боловсролыг бол хөгжих эрх зүйн холбогдох бусад актууд дээр судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэхэд санхүүжих хөрөнгө оруулалтыг дэмжих, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай эрдэмтэн судлаачдыг төрүүлэх гэсэн олон зорилтууд, хөтөлбөрүүдийг бий болгосон. Эрх зүйн актын хувьд маш олон бэлтгэл ажлуудыг боловсруулсан байгаа.

2 дугаар үндэслэл бол ерөөсөө дээд боловсролын хөгжлийн чиг хандлага бол сургалтаас судалгаанд чиглээд судалгаа нь ч гэсэн үр дүндээ эдийн засгаа хөгжүүлэх, эдийн засагт мэдлэг суурилсан судалгааны сургуулийг хөгжүүлэх бол хөгжлийн чиг хандлага бий болж байна аа. Дэлхийд Америкт бол 180 судалгааны сургууль, Солонгост бол 3, Японд 12 судалгааны бие даасан сургууль бол хөгжиж байна аа. Бид нар энэ дэлхий нийтийн дээд боловсрол, хөгжлийн чиг хандлага бол судалгааны их сургууль чиглэгдэж байгаа учраас бид нар энэ хуулийн төслийг бол оруулж ирж байгаа аа. Гэхдээ бие даасан эрх зүйн байдлын тухай хууль гэхээсээ

илүү хэлэлцүүлгийн явцад дээд боловсролын хуулийнхаа нөгөө нэг их сургуулийн ангилал дотроо институтэд бие ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Содномын Чинзориг гишүүн тодруулъя.

**С.Чинзориг:** Энх-Амгалан сайд аа. Яах вэ, хэлэлцүүлгийн үед нэлээн сайн ярих байх аа. Тэр мэргэжлийн боловсролтой холбоотой асуудлын бүтэц, тогтолцоо, өөрчлөлт эвдэгдэх гэж байгаа учраас мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын тухай хуулийг нь Засгийн газар өргөн бариад хамт хэлэлцвэл энэ хуулийг хэлэлцэхийг нь бол дэмжихэд бол бэлэн байна. Хамт ярихаас өөр өөр арга байхгүй.

2 дахь асуудал нь тэр 2 настай хүүхдийг цэцэрлэгт авахгүй гэхээр 1 асуудлыг шийдэж байгаа нь гарц байж магадгүй. 5 настай хүүхдийнхээ хангамжийг нэмэгдүүлж яах вэ, хүртээмжийг нь нэмэгдүүлж байгаа гэж. Нөгөө талаасаа 2 настай хүүхэдтэй ээжүүдийн ажил хөдөлмөр эрхлэх боломжийг нь тэр хэмжээгээр бас хааж байгаа гэдгээ бас нэлээн сайн бодох хэрэгтэй. Үүнийг одоо бид хэлэлцүүлгийг нэлээн сайн ярих ёстой байх.

3 дахь асуудал нь, ер нь бид Үндсэн хуульдаа ерөнхий эрдмийн боловсролыг чинь үнэ төлбөргүй олгоно оо гэсэн Үндсэн хуулийн заалттай. Тэгээд ерөнхий боловсролыг чинь асар өндөр төлбөртэй хувийн сургуулиуд яваад байдаг, мэдсэн ч мэдээгүй, юмыг мэдээгүй юм шиг ингээд одоо яваад байх уу. Цаашдаа энэ асуудлыг яах ёстой юм бэ?... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Чинзориг гишүүн ээ, энэ мэргэжлийн боловсролыг эвдээд байна гэдгээ та дахиж битгий хэлээрэй л гэж бодож байна. Энэ мэргэжлийн боловсролыг тогтолцоог эвдэж байгаа биш эвдэрчихсэн мэргэжлийн боловсролын тогтолцоогоо бид нар засъя л гэж байгаа юм. Засъя гэж байгаа. Буруу бодлого явуулаад эвдэрчихсэн тогтолцоогоо. Боловсролынхоо нэг хэсэг болгож. Боловсролынхоо тогтолцооны 1 хэсэг болгож.

Тантай санал нэг байна. Өнөөдөр Монгол Улсын Засгийн газраар хэлэлцээд мэргэжлийн боловсролын тухай хууль өргөн баригдсан. Ингээд боловсролынхоо ерөнхий хуультай хамт энэ хуулиуд хэлэлцэгдээд явах болов уу гэж бодож байна. Нэг байнгын хороогоор хэлэлцэгдэх биш яг мэргэжлийн Боловсрол, шинжлэх ухааны байнгын хороотойгоо хамтарсан ажлын хэсэг гаргаад энэ боловсролын тогтолцоонд үүссэн энэ гажгаа бид нар гажуудлаа засах, залруулах ийм бололцоо байх болов уу гэж бодож байгаа юм. Хэдэн МСҮТ-ийг дарж хэвтэх тухай асуудал ерөөсөө байж болохгүй ээ. Хэн нэгний ийм явцуу эрх ашиг байж болохгүй. Явцуу эрх ашиг байж болохгүй. Тийм учраас нийтийн эрх ашиг буюу нийтлэг эрх ашгийн үүднээс бид нар энэ боловсролынхоо ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Дамдинням Байнгын хорооны дарга.

**Г.Дамдинням:** Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн тогтолцоотой холбоотой асуудал дээр бас нэг зүйл нэмээд хэлчихье ээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд шилжсэн энэ үйл явдал бол үндсэндээ их томоохон алдаа болсон. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас зөвхөн Дархан-Уул аймагт байгаа 3 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв дээр ажлын хэсэг явуулаад судалгаа

хийгээд үзэхэд 3 мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв дээр мэргэжлийн давхардал асар их. Элсэгчдийн тоо хангалтгүй. Зарцуулж байгаа зардлын үр ашиг үр дүнгүй. Лабораториудын хүчин чадал шаардлагагүй, бүгдэд нь нэг гагнуурчны мэргэжил байдаг, бүгдэд нь оёдолчны мэргэжил байдаг, ийм одоо системийн завхрал руу орчихсон байгаа. Тэгэхээр боловсрол гэдэг бол мэргэжлийн байгууллагын мэргэжлийн системээр хийгддэг ажил аа. Хөдөлмөрийн зах зээл хариуцдаг байгууллага, яам бол эндээс бол больчихмоор л байгаа юм.

Тэгэхээр Их Хурлын дарга та одоо бас захирамж гаргаад тэгээд энэ манай Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо хоёрын ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Мэргэжлийн боловсролын тухай хууль маргааш өргөн баригдана. Тэгээд тэр үед нь тэгж шийдье гэж ярьж байгаа юм.

Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр боловсролын тухай ерөнхий хуулийн асуултыг бол Байнгын хороон дээр ингээд асуугаад авчихсан. Тэгэхээр энэ дээд боловсролын болон бусад хуулиас асууя аа. Дээд боловсролын тухай хуулийн. Монгол Улсын Засгийн газрын хөтөлбөр, 5 жилийн үндсэн зорилтууд дээр бид нар боловсролын бас суурь зарчмуудыг ер нь маш сайн томьёолсон байгаа. Тэгэхээр энэ зарчмууд нь одоо энэ хуулиуд дээр хэрхэн орж ирсэн юм бэ? Тухайлбал энэ 5 жилийн үндсэн хөтөлбөрт бол энэ төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгоно оо, эрх зүйн орчин сайжруулна аа гэсэн. Энэ заалт маань одоо судалгааны их сургуулийн хувьд бол хэрхэн хэр суусан бэ?

2 дугаарт нь энэ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.1 дээр яслийн үндэсний тогтолцоог сэргээж 1-2, хүүхэд харах үйлчилгээнд 2-3 насны хүүхдийг хамруулна аа. Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын оролцоог нэмэгдүүлж дэмжлэг үзүүлнэ гэж заасан байгаа. Гэтэл энэ хуулийн төсөл дээр маань сургуулийн өмнөх боловсролыг бол 3-5 насны хүүхэд гэдгээр оруулж ирсэн байна аа. Тэгээд 2 настай хүүхдийг бүлэг дүүргэлтийг харгалзан цэцэрлэгт хамруулж болно оо гэж. Энэ бол үндсэндээ хүлээж авах болохгүй заалт байна аа. Сургуулийн өмнөх нас тэр дотроо 3 хүртэлх нас бол одоо танин мэдэхүйн хувьд хөгжлийн хамгийн чухал нас аа. Тэгэхээр энэ одоо том үеийг бид нар ингээд хаяж болохгүй.

Тэгээд Монгол Ардын намын ард түмэндээ амласан гол амлалтын нэг бол энэ яслийн боловсролыг сэргээнэ ээ гэсэн заалт байгаа. Тийм учраас энэ заалтыг яагаад ингээд хасчхав аа гэдгийг асуумаар байна.

Дээд боловсролын тухай хуулийн 6.2.2 дээр бас байгаа. Энэ их, дээд сургууль ахисан түвшний сургалтыг дагнан эрхэлж болно оо гэсэн заалт байна. Тэгэхээр энэ заалт маань өнөөгийн Монголын нөхцөлд ер нь таарах юм уу? Яах вэ, зүгээр олон улсын жишгээр болбол одоо зөвхөн магистрын болон ахисан төвшний сургалт хийдэг сургуулиуд байна. Тэгэхдээ тэр сургуульд тавьдаг шалгуур бол маш өндөр байдаг аа. Жишээлбэл Америкийн нэгдсэн улсын хувьд болбол тухайн сургууль маань жил тутам тэдээс доошгүй докторын оюутанд сургалтын тэтгэлэг олгосон. Мөн одоо судалгаа шинжилгээнд таван саяас доошгүй доллар зарцуулсан байна аа гэх мэтийн. Ийм ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Мөнхцэцэг гишүүн нэмэлт 1 минут.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр олон улсад ахисан сургалтын одоо сургалт явуулдаг их сургуулиудад тавьдаг шаардлага ийм өндөр байдаг. Гэтэл Монголд ийм өндөр шаардлага хангах сургууль ер нь байх уу, үгүй юу?

Сүүлийн асуулт. Судалгааны их сургуулийн үндсэн концепц яг ямар концепт суурилсан юм бэ? Миний хувьд бол энэ судалгааны их сургуулийг бол дэмжиж байгаа, энэ бол олон улсын жишиг. Гэтэл яг энэ өргөн барьсан төсөл дээр маань судалгааны их сургууль гэдгийг бол зөвхөн энтрепренёр буюу одоо энэ бизнесийн сургууль гэдэг утгаар хийчихсэн юм биш үү? Яг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, тухайн доктор болон олон улсын тэтгэлэг хүртсэн оюутнуудын тоо. Тэгээд профессоруудын бие даасан байдал, академик сургалтын үр нөлөө, төгссөн оюутнуудын ажлын байр гэх мэт олон үзүүлэлт шалгуурууд бол энэ судалгааны их сургуулийн төсөл дээр бол сайн харагдахгүй байгаа юм л даа. Тийм учраас үүнийг ингээд тодруулж асуумаар байна.

**Г.Занданшатар:** Энх-Амгалан сайд. Энэ маш чухал асуултууд асууж байна. Суурь асуултууд.

**Л.Энх-Амгалан:** Дээд боловсролын засаглал удирдлагын асуудлаар Должин дарга тодорхой хариулт өгөөд, судалгааны их сургуулийн асуудлаар манай Намнан захирал энэ дээр тодорхой хариултууд өгчхөөрэй гэж бодож байна аа.

Би 2 настай хүүхдийн асуудлаар нэг өшөө түрүүнийхээ ярьсныг жаахан дэлгэрүүлээд ярьчихъя аа гэж бодож байна. 2 настай хүүхдүүдийг бид нар боловсролд хамаагүй ээ гэж хаяж байгаа асуудал биш ээ. 0-2 нас гэдэг бол угаасаа хүүхдийн хөгжлийн хамгийн алтан үе байдаг юм байна аа. Энэ бол эрүүл мэндийн асуудал, хүүхдийн хөгжлийн асуудлууд, нийгмийн хамгааллын асуудал учраас ер нь бол Монголын төр энэ 0-2 насны хүүхдийнхээ хүүхдийн хөгжлийн ийм цогц хөтөлбөр, бодлого гаргах ёстой юм байна лээ. Гаргах ёстой. Өнөөдөр яслийн тогтолцоотой улс орон байхгүй л дээ. Мөнхцэцэг гишүүн ээ. Францад л нэг тийм тогтолцоо байна. Тэгээд ер нь бол бусад улс орнууд болбол ингээд өдөр өнжүүлэх тийм ээ, манайхны ярьдгаар бол хүүхэд харах үйлчилгээ ч гэдэг юм уу энэ олон сонголттой ийм байгууллагын одоо өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээ ч гэдэг юм уу нэг ийм тогтолцоог л бид нар цаашдаа сонгох ёстой юм байна аа л гэж бодож байгаа. Харин ч бид нар ийм 2 настай хүүхдийн үйлчилгээг бид нар дэмжээд өгөх юм болбол олон ажилгүй эмэгтэйчүүдийг ажлын байртай болгох ийм нийгмийн асуудлуудыг давхар шийдэх ёстой. Яагаад ер нь энэ 2 настай хүүхэд дээр бид нар ийм асуудал хөндөөд байгаа юм бэ гэхээр ерөөсөө 2 настай хүүхдийг ингээд яслыд бүртгэхээр намар бүртгүүлсэн 40 хүүхдийн 30 нь байхгүй болчихдог хавар. 10 хүүхэд нь л үлддэг. Маш их өвчлөл. Ханиад томууны үед өвчлөл их байдаг учраас үндсэндээ ингээд эцэг эхчүүд нь бараг нөгөө яслыд бүртгүүлсэн хүүхдүүдээ ингээд нийт бүртгүүлсэн хүүхдийг чинь бараг үндсэндээ 70 хувь нь яслыдаа ирдэггүй юм байна аа. Ингээд нөгөө нэг сургуулиудын одоо цэцэрлэгүүдийн сул орон тоо хувьсах зардлууд санхүүжигдээд явж байдаг нэг ийм асуудал байгаа юм. Тэгэхээр бид нар энэ 0-2 насны асуудлыг бид нар хөсөр хаяхгүй ээ. Энэ болбол Монголын төрийн хамгийн том бодлого үр хүүхдүүд ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Содномын Должин. 85.

**С.Должин:** Дээд боловсролын асуудал бас нэлээн анхаарал татсан хуулийн зохицуулалт байгаа. Ер нь бол дэд боловсролын засаглалын эрх зүйн зохицуулалтыг бол нийтдээ 10 удаа болбол хуулийн өөрчлөлт орсон байна лээ. Би түрүүн өнгөрсөн, үйлчилж байсан хуулиудаасаа хамгийн гол онцлог зохицуулалт болбол удирдах зөвлөлийг 7-15 гишүүнтэй бүрдүүлээд үүнээс 51 хувь нь үүсгэн байгуулагчийн төлөөлөл байна аа гэсэн төрийн өмчит хуулийн их сургуулиуд дээр. Гэхдээ үүсгэн байгуулагчдын төлөөллийг зөвхөн хамруулахгүй, өөрөөр хэлбэл удирдах зөвлөлийг үүсгэн байгуулагч нь бизнесийн төлөөлөл, орон нутгийн төрийн байгууллагын төлөөлөл, тухайн сургуулийн багш, суралцагч, төгсөгч мөн хараат бус гишүүдийн бүрэлдэхүүнтэй байхаар харьцангуй нийгмийн боловсролын эрх зүйн харилцаанд оролцож байгаа субъектүүдийн төлөөллийн массыг бол нэлээн хангаж бас зохицуулсан шинэлэг зохицуулалт бол болсон.

2 дугаарт өмнө нь болбол их сургуулиудын гүйцэтгэх засаглал буюу ректор буюу захирлуудыг шууд удирдах зөвлөл буюу сонгон шалгаруулалтаар яамнаас шууд томилдог байсан. Өнөөдөр дээд боловсролын засаглалын хамгийн том өөрчлөлт болбол удирдах сонгон шалгаруулалт хийгээд удирдах зөвлөлөөс томилдог болж байгаа. Энэ удирдах зөвлөл нь болохоороо массын төлөөллийг болбол бүрэлдэхүүнтэй байгаа учраас харьцангуй нээлттэй шударга, арай дэвшилттэй зохицуулалт болсон гэж үзэж байна.

**Г.Занданшатар:** Арай дэвшилттэй юу. Арай дэвшилттэй биш олонх нь үүсгэн байгуулагч, эзэд томилдог байх юм бол ТУЗ-ийн хараат бус академик эрх чөлөө, эрдмийн эрх чөлөө чинь хоосон яриа л боллоо. Лоозон л боллоо.

Төмөрпүрэвийн Намнан ШУТИС-ийн дэд захирал.

**Т.Намнан:** Би товчхон хариулт хэлье. Энэ судалгааны их сургууль бол түрүүн би бас товчхон хэлсэн. Улс орны нийгэм эдийн засгийн хөгжилд чухал үүрэгтэй ийм их сургууль байх ёстой. Тэгэхээр олон улсын судалгаагаар бол эдийн засагчдын судалгаа, судлаачдын судалгаагаар энэ судалгаанд оруулсан хөрөнгө оруулалт, эдийн засгийг буцаагаад 20-40 хувь өсгөж байдаг гэсэн. Ийм олон судалгаанууд байдаг л даа. Тэгэхээр судалгааны их сургуульд тавигдах гол шаардлага шалгуур бол нэг их тоо гэхээсээ илүүтэй энд бол гол нь одоо улс орны нийгэм эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэсэн, одоо үнэ цэнэтэй судалгаануудыг хийдэг, тэнд хүний капиталыг бий болгож чаддаг, сүлжээ лабораториудыг бий болгож чаддаг, түүн дээрээ нөөцийн төвлөрлийг, нөөцийн уялдаа холбоо, холбоосыг энэ мэдлэг чадварын сүлжээг бий болгож ажиллаж чаддаг энэ тогтолцоонууд багцаараа орж ирж байгаа юм л даа. Тэгж байж бид энийг арай өөр түвшинд аваачихгүй бол одоо манай ахисан түвшний судлаачид бол их л тарамдсан байдалтай байгаа л даа. Энд тэнд байрласан, маш их давхардсан судалгаанууд хийдэг. Давхардсан хөрөнгө оруулалтууд татдаг лабораториудтай гээд. Энэ болгоныг, бас менежментийг бид зөв зохион байгуулалтад оруулж чадвал энэ сургуулиараа дамжуулаад улс орныхоо эдийн засгийн нөгөө гол гол түлхүүр үзүүлэлтийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой байх болов уу гэж харж байгаа.

2 дугаарт энэ гол асуудал бол санхүүгийн бие даасан байдал, санхүүжилт, засаглалын асуудал байгаа. Мэдээж одоо судалгаа инновац бол өнөөдөр хийгээд маргааш үр дүн гарчихдаггүй учраас энэ бол урт хугацааны тогтвортой дэмжлэгүүд бий болгох учиртай. Энэ дэмжлэгүүдийг зөвхөн төрөөс биш бид аль болох олон талын оролцоог бий болгоход их анхаарах ёстой юм л гэж ойлгоод байгаа. Бусад

орны жишиг туршлагаас харахад. Тэгэхээр мэдээж энэ засаглалд нь бол одоо олон талын оролцоо гэдэг нь орон нутгийн, бизнесийн байгууллагууд, янз бүрийн төлөөллүүдийг бид нар оролцуулах ёстой. Дээд боловсрол өөрөө бүх салбараа чирж явдаг ийм том өөрөө оюуны цөм байх ёстой юм л даа. Тэгэхээр энд бол одоо тухайн орон нутагт байршиж байгаа их сургуулийн одоо тэр орон нутгийн хөгжлийг дэмжихэд энэ их сургуулийн нөөц боломжийг дайчилдаг байх ёстой юм. Тэгэхээр энд бол их олон талын оролцоо бий болж байж засаглал нь зөв бүрдэж байж хараат бус санхүүтэй байж байж цаашаа зөв хөгжих ёстой юм аа л гэж харж байгаа юм. Тэгэхээр энэ гаргалгааг энэ судалгааны их сургуулиар дамжуулан хийх юм аа л гэж ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэрэнжамц Мөнхцэцэг гишүүн нэмж тодруулъя.

**Ц.Мөнхцэцэг:** Энэ нөгөө судалгааны их сургуулийн яг суурь концепц юу юм бэ гэж асуугаад байгаа юм. Таны ярьж байгаа төслийг харахаар болбол ер нь бол эдийн засаг, нийгэм, бизнесийн үр өгөөжийг харсан, за ийм одоо үр өгөөж бий болгож чадаж байгаа сургуулийг бол судалгааны их сургууль гэж ойлгох гээд байна. Гэхдээ суурь шинжлэх ухаан, байгалийн шинжлэх ухаан, эрүүл мэнд, анагаах хүмүүнлэгийн шинжлэх ухаанд заавал тийм бизнесийн ашиг гарахгүй ээ. Энэ чинь угаасаа улс орны хөгжлийн томоохон стратегийн салбарууд. Гэтэл зөвхөн одоо нэг сургууль гэдэг юм уу, бизнесийн ашиг сонирхлын үүднээс инновацыг дэмжсэн, тэгээд тухайн одоо сургуулийн үр ашиг нь бол тухайн орон нутагт бас үр дүн өгнө энэ тэр гэх мэтээр ярихаар энэ бол одоо нөгөө энтрепренёр их сургууль юм шиг ийм утгаар харагдаад байна аа. Хэрвээ бид нар судалгааны их сургуулийг дэмжих гэж байгаа болбол шинжлэх ухааны, тэр дотор даяаршлын нөхцөл дэх хүний хөгжил бусад одоо шинжлэх ухааны томоохон хөгжлийг бол ярих ёстой. Тэгэхгүйгээр зөвхөн бизнесийн үр ашиг, өгөөж гэдэг талаасаа харах юм болбол бид нар энэ маань яг судалгааны их сургуулийн суурь концепц биш болно оо. Өөрөөр хэлбэл концепцын хувьд энэ чинь шал ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Мөнхцэцэг гишүүн ээ, ер нь судалгааны их сургуулийн үндсэн 10 шинж яг юу байдаг юм бэ гэдэг энэ хэфэйн тунхаглал гэж 2013 оны тунхаглалаар ингээд 10 үндсэн зарчмыг нь тодорхойлоод өгчихсөн. Тэгэхээр бид нарын энэ өргөн барьж байгаа энэ хуулийн төсөөллөөр болбол бид нар хэзээ ч энэ судалгааны их сургуулийг энтрепренёр буюу бизнесийн зарчмаар бид нар хөгжүүлэе гэдэг ийм хуулийг өнөөдөр өргөн бариагүй ээ. Бид нарын өргөн барьж байгаа одоо гол зарчим болбол магадгүй Монгол Улсын Их сургууль, магадгүй Анагаах ухааны их сургууль, магадгүй ШУТИС-ийн саяын 6 сургуулийн нэгдэл, Монгол Улсын Их сургуулийн нэрийн дор нэгдэж байгаа 6 сургуулийн нэгдэл, цаашдаа анхны Монголын их судалгааны их сургууль болох энэ статус нь дээшлээд тавих энэ боломжийг л бид нар харж байгаа. Тийм учраас үндсэндээ болбол энэ судалгааны их сургуулийн хамгийн үндсэн үүрэг бол Монгол Улсын хөгжлийн өмнө тулгамдаж байгаа ямар асуудлууд байна, тэр асуудлуудыг л шаардлагатай шийдлүүдийг гаргаж байх ёстой. Ийм л мэдлэгийн төвлөрөл байх ёстой л ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Одоо Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Балжинням:** Баярлалаа. Тэгэхээр энэ боловсролын багц хууль бол Монгол Улсын Үндсэн хуулийн араас орох, цаашдаа Монгол Улс ямар иргэнтэй

байх юм, ямар хөгжилтэй байхыг тодорхойлсон ийм хөгжлийн суурь хууль юм аа. Тэгээд энэ хуулийн энэ СӨБ болон сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын зорилго дээр энэ сайн зан чанартай иргэн бэлдэх гэдэг энэ үг авагдчихсан байгаа юм аа. Тийм учраас намар энэ хуулийг хэлэлцүүлэхээр орж ирэхэд үүнийг бас энэ ажлын хэсэг анхаарч, ялангуяа СӨБ, ерөнхий боловсролын энэ хууль дээр сайн зан чанартай иргэн болох ийм зорилготой орж ирээсэй гэж 1 дүгээрт хүсэж байна аа.

Сая энэ 0-3 нас гээд л зөндөө ярьж байна. Сайд өөрөө хэлж байна, мэдлэг чадвар, хандлага гээд. Тэгэхээр Монгол Улсын хамгийн үнэт баялаг болсон энэ иргэнээ сайн зан чанартай, зөв хүн болгож бэлтгэж байж бид нар ёс зүйтэй нийгмийг бүтээх гээд байгаа юм. Тэгэхээр энэ зан чанарын хөтөлбөр гэдэг бол одоо бидний хамгийн гол хийх ажил шүү. Тэгээд яг энэ чухал үед сэтгэл зүйчдээ түшиж тулж нийгмийг соён гэгээрүүлэх энэ ялангуяа 0-3 настай эцэг эхчүүдээ соён гэгээрүүлэх энэ 1940-өөд, 1960-аад онд энэ сэтгэл зүйчдийн аль хэдийн одоо энэ баталчихсан онолын дагуу 0-3 насанд хүүхдийн зан чанар сайн тогтдог оо. Эхийн хайр, эцгийн хамгаалалт хүүхдэд хэрэгтэй байдаг юм аа гэдэг энэ зүйлийг бол ойлгуулж соён гэгээрүүлмээр байна аа. Ер нь бол Монгол Улсын Засгийн газар өнөөдөр Нэгдсэн үндэсний байгууллагад бүртгэлтэй 200-аад улс орноос ганцаархнаа 2, 3, 4, 5 насанд нь цэцэрлэгийн зардлыг нь бүрэн төлдөг. Ийм Засгийн газар байгаа. 2 настай хүүхдийн эцэг эхчүүдийг сонголтоор тэр яслд юм уу, эсвэл одоо өдөр өнжүүлэх, хүүхэд харах үйлчилгээнд хамруулах гэдэг энэ бодлого бол маш зөв өө гэдгийг бол би дэмжиж хэлж байна ... / минут дуусав/

**Г.Занданшатар:** Балжиннямын Баярсайхан гишүүн 1 минут.

**Б.Баярсайхан:** 2 дугаарт нь энэ сайдын сая ярьж байгаа энэ орон нутагт боловсролын салбарын томилгоог тухайн орон нутагт засаг дарга нар томилдог байх. Энэ асуудлыг одоо өөрчлөх гэж байгаад бас маш их баяртай байна. Дамдинням дарга сая хэллээ, ялсан аймагтаа багш нараа байлгадаг гээд. Завхан аймагт бол Монгол Ардын нам ялсан. Гэхдээ би энэ дээр бол боловсролын салбарыг улс төржүүлмээргүй байна, яг тэр мэргэжлийн багш нар нь сургуулиа удирдаад, цэцэрлэгээ удирдаад ингээд явах ёстой гэдэг дээр бол 100 хувь санал нэгдэж байна.

Сая энэ Засгийн газраар МСҮТ-ийн хууль орсон гэхихлээ. Энх-Амгалан сайд аа, энэ маань энэ боловсролынхоо хуультай яаж уялдах юм. Мөн энэ Бат-Эрдэнэ гишүүн нарын өргөн бариад байгаа энэ хүмүүнлэгийн боловсрол гээд байгаа. Энэ боловсролын хууль нь энэ боловсролынхоо багц хуультай уялдаж явах юм уу гэсэн ийм асуулт байна.

**Г.Занданшатар:** Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Баярсайхан гишүүнтэй ерөөсөө л санал нэг байгаа. Өнөөдөр энэ сургуулийн өмнөх боловсрол, бага боловсрол дээр байгаа Монгол хүүхэд тэр нь яг ямар хүүхэд байна вэ гэж. Тэгэхээр хөдөлгөөний гүн дутагдалдаа орсон юм байна аа, нэгдүгээрт. Хоёрдугаарт хүчилтөрөгчийн гүн дутагдалд орсон байна аа, цэцэрлэгийн хүүхдүүд, бага ангийн хүүхдүүд. Насандаа ахадсан ачаалалтай байна аа. Зан төлөвийн өөрчлөлтөд орсон ийм л хүүхдүүд байгаа. Ийм хүүхдүүд болчихсон. Судалгаагаар ийм судалгаа харагдаж байгаа юм. Тийм учраас бид нар одоо яг үнэхээр энэ сургуулийн өмнөх боловсрол. Энэ бага боловсрол дээр бид нар энэ хүүхдийнх нь эзэмших ёстой мэдлэг гэхээсээ илүү

чадвар, тэр төлөвшлийн асуудал дээр бид нар үнэхээр анхаарлаа хандуулах цаг нь болчихжээ. Энэ дуу хөгжмийн хөтөлбөрийн асуудлыг бид нар шинэ хөтөлбөрөөр, тэр шинэ хөтөлбөрөөр дамжиж, энэ дуу хөгжмөөр дамжиж, биеийн тамираар дамжиж, энэ эрүүл хооллолтоор дамжиж бид нар зөв Монгол хүн төлөвшүүлэх ийм бодлого бид нар хэрэгжих ёстой гэж ойлгож байгаа. Энэ дээрээ нэмэх нь зан төлөвийн, төлөвшил, таны хэлж байгаа. Эмошн интелиженс гэж сүүлийн үед ярьдаг байсан. Сэтгэл зүрхний боловсрол. Тийм учраас бид нар ай кю өндөртэй хүн бэлдэх нь Монголын нийгэмд ирээдүй чухал байна уу? Эсхүл ик буюу эмошн интерлизинг буюу зүрх сэтгэлийн боловсролтой хүмүүсийг бэлдэх нь өнөөдөр Монголын ирээдүйд чухал байна уу гээд жигнэж үзэхээр зүрх сэтгэлийн боловсролтой буюу илүү их хүнлэг, энэрэнгүй, багаар ажиллах чадвартай, бусдыг ойлгодог, өөрийгөө бусдын оронд тавьж чаддаг ийм л хүмүүсийг бид нар төлөвшүүлэх, хүмүүжүүлэх. Энэ хэрэгцээ шаардлага өнөөдөр боловсролын салбарт хүрчихсэн байна аа л гэж байна. Тийм учраас бид нар өнөөдрийн мэргэжлийн үндэсний шаталсан бүтэц дээр үндэслэсэн бол Монголын боловсролын тогтолцоог бид нар зурах гэж үзэж байгаа юм. Аль ч шатанд нь, аль түвшинд нь бид нар ямар мэдлэг, ямар чадвар ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Тэгээд хэлэлцэх эсэхийг дэмжсэний дараа нийгмийн өргөн хүрээнд хэлэлцүүлгүүдийг зохион байгуулах шаардлагатай. Боловсролоос ангид хүн гэр бүл гэж үндсэндээ нэг ч байхгүй. Тэгээд саяын яриа, асуулт, хариултын явцад гишүүдийн асуусан асуулт, Цэрэнжамцын Мөнхцэцэг, Балжиннямын Баярсайхан гишүүдийн ингээд асуугаад тодруулаад байгаа тэр их, дээд сургуулиудыг корпорацын засаглалд шилжүүлэх нь зөв. Тэгэхдээ корпорацын засаглал гэдэг чинь сонирхлын бүлгүүд, нийгмийн төлөөлөл, трасти нарын идэвхтэй оролцоог хангаж байж эрх барихад оролцоо нь хангагдана. 2016 оны хуулиар байх аа үүнийг хангаж үүсгэн байгуулагч, эзний эрх оролцоог харьцангуй ингээд хязгаарласан академийн эрх чөлөөг бий болгоход чиглэсэн профессоруудын оролцоог хангах гэсэн тогтолцоог одоо бүрдүүлэхийг эрмэлзэж байсан боловч үүнийг аваад хаячихсаныг огт хөндөөгүй байлаа.

Сая одоо ингээд сайд өгөөд халт харахад л буруу байж магадгүй. Энэ маш их хөдөлмөр, маш олон хүний ажил, маш сайн дэвшил болсон гэдэгт эргэлзэхгүй байна. Тэгэхдээ ерөөсөө л энэ боловсролын хуулийн тэр академик фридом буюу эрдмийн эрх чөлөө, институционал буюу институцийн бие даасан байдлыг хангах, үүнийг л суурь болгож авч байвал их дээд сургуулиуд өөрөө аяндаа жигдэрчихнэ. Хувийн их, дээд сургуулиуд ч гэсэн тэр профессоруудын оролцоо, эрдмийн манлайлал нь ТУЗ-даа илүү болчихвол ашгийн төлөө биш байх үндсэн зорилго нь хангагдаад хөрөнгө оруулалт, цалин хөлсөндөө үүнийгээ оролцуулаад одоо тоо ийм аргаар цөөлнө үү гэхээс биш одоо хүчээр ч юм уу карнегийн ангиллыг авчраад карнегийн ангиллыг шууд одоо тэр чинь зөвлөмж болохоос биш хуульчилж болдоггүй нэр хүндийн одоо баталгаа гэдэг юм уу, нөгөө хийж байгаа судалгааныхаа үр дүнгээр нэрэндээ болж төр буюу хувийн хэвшил судалгааны захиалга өгөх тэр нэр хүндийн баталгаа болно шүү дээ. Тэгэхээр энэ дээд боловсролоо универсал болгох нь энэ аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал дижитал эдийн засгийн хувьд түгээмэл болоод өөрчлөгдөж байхад дэлхийн томоохон их дээд сургуулиуд хүртэл одоо өөрчлөгдөж байхад бид нар тэднүүсийн нөгөө өөрчлөх гээд байгаа юмыг нь хуулж шууд хуульчлах нь аль зэрэг зөв юм бэ? гэх мэтчилэн ийм маргааны сэдвүүд олон гарч ирэх байх.

Одоо Харвард ч гэдэг юм уу, Стэнфордын их сургуулийн эндаммент фанд менежменттэй корпорацын засаглалд шилжүүлж байна. Ингээд дижитал хувьсгалын үед шал өөрчлөгдөж байна. Тэгээд л хамгийн гол үндэс нь бол ерөөсөө тэр институцийн автономит бие даасан байдал, академик эрх чөлөө, багш нарын цалин хөлс гээд. Ийм учраас энэ Америкийн загварт бол манай нийгэм бэлэн биш байгаа. Элит давхарга нимгэн байна. Ийм учраас ядаж профессоруудын жинтэй нөлөө оролцоотой засаглалыг бий болгох, эрдмийн зөвлөлд эрх мэдлийг шилжүүлэх замаар төрийн өмчийн их сургуулийн засаглалыг Германыхтай төстэй болгож болно. Тэгээд дээр нь энэ дотор бас нэг манай Мөнхцэцэг гишүүн энэ тэрийн ярьдаг нэг үзэл баримтлалын нэг ялгаа байна аа. Одоо орлого багатай иргэд, авьяас чадвартай хүүхдүүд, иргэдийн суралцах боломжийг дэмжих, нийгмийн тэгш боломжийг суралцах боловсролын тэгш боломжийг хангана гэж яриад байсан мөртөө тэр энэ тэр асуудлуудаас авахуулаад хууль дээрээ анхаарах асуудлууд байж магадгүйг бас мэдээж энэ асуудал тодорхой хэмжээгээр байгаа нь ойлгомжтой. Хэлэлцүүлгийн явцад зунжин нэлээн өргөн хэмжээнд хууль тус бүрээрээ нэлээн өргөн хүрээтэй хэлэлцүүлгүүд явах нь зөв байх гэж бодож байна аа, эрхэм гишүүд ээ.

Манай Дааданхүүгийн Батбаатар Төрийн нарийн бичгийн дарга чинь анх эрхэм гишүүн гэдэг үгийг гаргасан хүн байгаа шүү, бас.

Ингээд санал хураалт явуулна. Санал хураалтын өмнө дэмжсэн, дэмжээгүй 3 хүртэл гишүүн үг хэлж болно. Үг хэлэх гишүүн байна уу.

6 гишүүнээр л тасална. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлнэ.

Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн хамгийн хурдан байлаа.

**Ё.Баатарбилэг:** Баярлалаа. Тэгэхээр боловсролын салбарын энэ хууль, эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд энэ багц хууль орж ирж байгаа. Хэлэлцэх эсэхийг дэмжиж байгаа. Өнөөдөр Байнгын хороон дээр бас нэлээд нухацтай ярьсан. Цаг хугацааны хувьд бас нэлээн шахуу орж ирлээ. Хаврын чуулганы төгсгөл рүү. Нэлээн шахуу богино хугацаанд хэлэлцэх эсэхийн асуудал яригдаад явж байна. Хуульд бол бас энэ боловсролын салбарт олон жил яригдсан тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, эрх зүйн орчных нь бас зайлшгүй өөрчлөлт оруулах ёстой заалтууд орж ирсэн байна аа. Энэ дээр бол сайшаалтай зүйлс нэлээд байгаа.

Нөгөө талаараа өнгөрсөн жил энэ хуулийн төсөл боловсруулах явцад нийгмийн хэлэлцүүлгүүд явагдаж, боловсролын салбарынхантай, эцэг эхчүүдтэйгээ нийгмийн бүхий л бүлгүүдтэй хуулийн төсөлд санал авч, хэлэлцүүлж байсан нэлээд олон асуудлууд бас тусгагдаагүй буюу арай өөр томъёоллоор тусгагдсан зарчмын асуудлууд байна. Жишээлэхэд манайд гишүүд нэлээн ярилаа. Энэ ерөнхий боловсролыг 12 жилээр болгож байгааг заавал эзэмшүүлэх боловсрол болгож байх жишээний. Дунд сургууль төгсөөд ингээд гэрчилгээ олгоно энэ тэр гээд. Ингээд тэр нь ингээд хоорондоо зөрчилдчихсэн ийм заалтууд юмнууд бол байж байна аа.

Дээр нь энэ багш нарын тэтгэврийн нас одоо яг багш нартай хэлэлцүүлэг хийж байхад тэтгэврийн насыг 50, 55 болгоод өгөөч гэдэг багш нарын энэ олон жил ажилласан цалин урамшууллын асуудлууд гээд маш олон асуудлууд, багш

нарын маань нийгмийн баталгааны асуудлууд, энэ олон асуудлууд яригдаж байсан.

Нэлээд олон асуудлууд бол тусгаагүй буюу арай өөр томъёоллоор туссан асуудлууд байна. Мэдээж хэлэлцэх эсэхийн дараа ажлын хэсэг байгуулагдаад, ажлын хэсэг дээр бол тодорхой асуудлууд яригдана гэж ойлгож байна. Энэ юмнуудаа бол ажлын хэсэг дээр саналаа хэлээд явна.

Энэ мэргэжлийн сургалт, мэргэжлийн боловсролынхоо асуудлыг одоо нэг тийш нь болгох ёстой. Энэ хуулийн хүрээнд. Энэ чинь Монгол Улсын боловсролын тогтолцооны гажуудал болчихоод байгаа шүү дээ. Одоо хөдөлмөрийн байгууллага биш. Энэ мэргэжлийн боловсролын хуулийг хөдөлмөрийн асуудал хариуцсан Байнгын хороогоор хэлэлцээд хөдөлмөрийн яам хариуцаад явж байдаг. Тэнд багш суралцагч нар ажиллаж суралцаж байдаг. Энэ чинь сургалтын байгууллага байхгүй юу, хөдөлмөрийн байгууллага биш. Тэгэхээр энийгээ одоо нэг талдаа гаргаад, хуулиа бүр цогц болгоод ингээд явах нь зүйтэй. Үүнийг бол бас ажлын хэсэг дээр бүр яриад үүнийгээ нэг тийш нь болгоод явах нь зүйтэй. Энэ Засгийн газар дээрээ уг нь 2 сайд яриад ойлголцсон гэж би ойлгосон.

Энэ дээр тэр нэг албан болон албан бус боловсрол, дээр нь амьдралын орчноос суралцах боловсрол гээд ингээд өмнө нь яах вэ бид нар мэдэхгүй байж магадгүй. Тэгэхдээ яг Монголынхоо хөрсөн дээр буусан, Монголынхоо сургалтын орчин, суралцагчид, багш энэ боловсролын салбарынхаа бас өнгийг тодорхойлсон онцлогийг тодорхойлсон ийм юмнуудаа, бас ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

**Ц.Мөнхцэцэг:** Энэ Засгийн газраас оруулж ирж байгаа боловсролын тухай багц хуулиудыг бол дэмжиж байна аа. Нийгэмд маш их хүлээлт үүсгэсэн ийм хуулиуд байгаа. Тэр дотроо энэ боловсролын тухай ерөнхий хуульд болбол зорилгоосоо авахуулаад бас одоо өмнөх хуулиудтай харьцуулахад ихээхэн дэвшил гарсан. Мөн одоо тодорхой чиглэлээр ерөнхий боловсролын суурь үйлчилгээ, ахлах сургуулиуд, сургалтын хувилга зардал гэх мэтийг одоо шинээр тооцоолох гэх мэтээр их шинэлэг юмнууд орж ирж байгаа.

Мөн үүнтэй зэрэгцээд ашгийн бус сургалтын байгууллагыг төрөөс дэмжих, боловсролыг тэгш хүртээмжтэй болгох тал дээр мөн анхаарч Их Хурал дээр гарах ажлын хэсгүүд маань энэ дээр бид нар бол анхаараад ажиллаад явна аа гэж бодож байгаа.

Мөн өнөөдөр бид нар хэлэлцсэн Дээд боловсролын тухай хуульд судалгааны их сургуулийн тухай хуулиуд дээр мөн бас өөрт нь сайжруулах зүйл бол нэлээд байна. Ер нь бол судалгааны их сургууль дээд боловсрол болбол олон улсад, тухайн улс орны үндэстний чадавхыг нэмэгдүүлдэг, олон улсад өрсөлдөх чадварыг нэмэгдүүлдэг ийм гол одоо хүчин зүйл учраас төр бол дэмжиж байх ёстой. Манай их, дээд сургуулиуд бол маш их хүлээлттэй байгаа. Судалгааны зардал төрөөс нэмэх, багш нарын судалгаа шинжилгээний чадварыг хөгжүүлэх, боловсруулах тал дээр бол төрийн дэмжлэг яах аргагүй хэрэгтэй байгаа. Тийм учраас боловсролын салбараас орж ирсэн багш хүний хувьд болбол энэ боловсролын гол зарчмуудыг үр дүнтэй өгөх, төрөөс олгох боловсролын бодлогыг одоо тодорхой болгох, судалгааны их дээд сургууль, одоо бүх шатны боловсролын байгууллагын үйлчилгээг чанаржуулах, багш, ажилтны нийгмийн

халамжийг шийдэх, боловсролын тэгш хүртээмжтэй, тасралтгүй үржлийг хангах тухайд болбол зарчмын тодорхой заалтуудыг бас ажлын хэсэг дээр ингээд оруулаад явна аа.

Ер нь бол энэ ташрамд хэлэхэд аливаа улсын төр ямар ч үед боловсролыг бол тасралтгүй болгож, боловсролын асуудалд онцгойлон анхаарч байх ёстой. Цар тахлын хуулиар бид нар бол бас тодорхой олон зардлуудыг манай боловсролын төсвөөс бол танагдсан байгаа. Цаашид бид нар ямар ч ийм хямрал, дайн дажин гарлаа гэхэд боловсролын үйлчилгээний зардлыг танах ёсгүй. Боловсролын үйлчилгээг тасралтгүй хүрэх ёстой гэдэг тал дээр энэ зарчмыг бид нар боловсролын хуульдаа суулгаж өгөх ёстой гэсэн бас хатуу байр суурь илэрхийлмээр байна. Баярлалаа.

**Г.Занданшатар:** Дэмжиж үг хэллээ. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн.

**Л.Энх-Амгалан:** Гишүүддээ баярлалаа. Энэ хууль бол бас нэлээн хэлэлцүүлэг хийж байж үндэсний зөвшилцлийн зарчмаар батлагдах ёстой хууль юм байгаа юм аа. Зүгээр яах вэ яагаад энэ хуулийг өргөн барихгүй, жаахан цаг хугацаа алдчихав аа гэдэг бас нэлээн ийм шүүмжлэл байгаа юм аа. Үүнийг бол би бас нэлээн ажил хэрэгчээр хүлээж авна. Энэ шүүмжлэлийг. Ер нь тодорхой нэг хуулийг сайн, бүрэн бүтэн ийм төгс хууль бол хэзээ ч байхгүй. Гэлээ гэхдээ энэ хуулийг бас үнэхээр гүйцээн боловсруулах ийм хэрэгцээ шаардлага өнөөдөр байсан. Өнөөдөр Монгол Улсад байгаа ядуурал, ажилгүйдэл, нийгмийн тэгш бус байдал өнөөдөр энэ боловсролоос л угшилтай гэж байгаа юм. Боловсролоос л угшилтай. Өнөөдөр Монголд байгаа боловсролын тогтолцоо болбол цөөнхийн боловсрол буюу элит боловсрол. Хэн мөнгөтэй нь өнөөдөр хүүхдэдээ илүү боловсрол олгодог ийм л элит боловсролын тогтолцоо байгаа. Тэгэхээр Монголын үр хүүхэд бүхэн өнөөдөр чанартай, хүртээмжтэй ийм боловсрол авах, энэ боломжуудыг бид нар бий болгох ёстой юм. Тийм учраас өнөөдөр энэ хуулийн хэлэлцүүлэг дээр бид нар энэ Монголын боловсролын салбарын үндсийн үндэс болсон мэргэжлийн үндэсний шаталсан бүтэц гэдгийн ач холбогдлыг бид нар нэгдүгээрт ойлгомоор байна аа. Гишүүдээ. Ойлгомоор байна. Энэ дээрээ үндэслэж бид нар боловсролынхоо тогтолцоо, боловсролын тогтолцоонд үүссэн энэ гажуудлуудыг арилгах ёстой гэж ойлгож байна.

Тийм учраас цаашдаа бид нар энэ боловсролын удирдлагын тогтолцоо нь оновчтой, улс төрөөс хараат бус мерит зарчимд суурилсан энэ тогтолцоог бий болгох. Өнөөдөр энэ ковидын үе Монголчуудад маш том боломж олгож байгаа. Ямар боломж олгож байна гэхээр цахим шилжилт хийх энэ боломжийг олгож байгаа. Боловсролын салбарт өнөөдөр хоцрогдлоо арилгах, боловсролын тэгш хүртээмжтэй үйлчилгээг өгөх хамгийн том боломж болбол энэ цахим шилжилт гэж харж байгаа. Цаашдаа бид нар ерөөсөө энэ хүүхдүүдийнхээ хүүхэд бүрийн сурлагын ахиц дэвшлийг үнэлдэг, энэ дээр үндэслэсэн багшийн сургуулийн санхүүжилтүүд, хүүхдүүдийн хувьсах санхүүжилтийн тогтолцоонд шилжих ийм зайлшгүй шаардлагууд өнөөдөр үүссэн байна аа. Тийм учраас Монгол Улс өнөөдөр ямар нэгэн гаднын хөтөлбөрийн нэрээр биш өнөөдөр яг Монголынхоо хөрсөн дээр буусан Монгол хүүхдийн нас, оюуны чадавх, авьяас сонирхолд нийцсэн ийм л хөтөлбөрүүдийг бид нар хөрсөн дээрээ буулгаж, ийм л боловсролын чанарын тогтолцоог өнөөдөр Монголдоо бий болгох ийм шинэчлэлүүдийг хийх л өөрчлөлтүүдийг эрх зүйн өөрчлөлтүүдийг хийх шаардлага гарсан учраас тодорхой 8 ажлын хэсэг гаргаж, 3 сарын хугацаанд ажиллаж, ингээд энэ үндсэн дээр энэ ажлын хэсгээс гаргасан зөвлөмжийн үндсэн дээр бид нар

боловсролынхоо ерөнхий хуулийг гүйцээн боловсруулж өргөн барьж байгаа юм шүү.

Тэгээд энэ зунжингаа, энэ намаржингаа энэ хэлэлцүүлэг одоо явах ийм боломжууд нь өнөөдөр байгаа гэдгийг бас та бүхэндээ хэлье. Ингээд гишүүддээ их баярлалаа.

**Г.Занданшатар:** Чинбатын Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Боловсролын багц хуулийг хэлэлцэх асуудлыг бол дэмжиж байгаа. Тэгээд энэ удаагийн хууль дээр сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсрол гээд бүхий л тогтолцоогоор нь харж сургалтын хөтөлбөр, заах арга зүй, сурах бичиг, багшийн цалин урамшуулал, хөгжил, багш бэлтгэх хөтөлбөр, боловсролын орчин санхүүжилт, цахим технологийн шилжилт үнэлгээ, магадлан итгэмжлэл чанар гээд одоо маш олон асуудлуудыг нь оруулж ирж байгаа гэж ойлгож байгаа.

Дээд боловсрол дээр нэг ийм санал байгаад байгаа юм аа. Бид нар мэргэжлийн сургалт үйлдвэрлэл мөн их сургуулийн асуудлыг хамтад нь цогцоор нь харж ингэж хэлэлцэх ёстой. Дээрээс нь их сургуулийг бол судалгааны их сургуулийн хууль гэж тусад нь гаргах шаардлагагүй гэж үзэж байгаа юм аа. Тэгээд дээрээс нь энэ их сургууль дээр хамгийн гоё, гол чухал асуудал бол түрүүн хэлж байна л даа. Бие даасан байдал болон академик фрийдом, академик эрх чөлөө энэ дээр нэмэгдээд одоо academic integrity гэж зүйл байдаг. Ёс суртахуун энэ интэгрити нь байж байж фрийдом нь олгогддог, тэгэхгүй бол одоо нөгөө багш нар чинь дуртай янз бүрийн хэрэгтэй, хэрэггүй эсвэл хор уршиг тарихаар энэ судалгаанууд руу явчихдаг байгаад байгаа юм.

Дээрээс нь энэ хуулиудаараа их сургуулиуд дээр бид нар тенур тогтолцоо, профессорын тенур тогтолцоог оруулах ёстой. Дээрээс нь засаглалыг нь бид нар улс төрөөс хараат болгох ёстой. Энэ хуулийн төсөл дээр удирдах зөвлөлийн 51 хувийг нь Засгийн газрын гишүүн томилно гэхчхэн байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ чинь ерөөсөө тэр мерит зарчимд суурилсан тийм засаглалын тогтолцоо биш болж байгаа юм. Үүнийг бол бид нар засах ёстой. Удирдах зөвлөл нь одоо олон нийтийг төлөөлсөн бизнесийн төлөөлөл, төгсөгчийн төлөөлөл, эрдэмтдийн төлөөллөөс бүрдсэн ийм төлөөлөл. Дундаасаа сойт комиций буюу судлан шалгаруулах комиссыг бүрдүүлээд, тэгээд нөгөө президентээ томилдог, тэр нь одоо провосто томилдог гээд яг энэ олон улсын жишиг рүү нь бид нар явах ёстой.

Дээрээс нь түрүүн энэ их сургуулийн ранкинг ярьж байна аа. Хамгийн гол ранкин бол QS Times болон Шанхай ранкинг байдаг. Тэр вебо метрикс бол ерөөсөө тийм албан ёсны ранкинг биш ээ. Энэ 3 ранкинг бол хамгийн гол нь их сургуулийн багш нарын тэр мэдлэг бүтээж байгаа, инновац бүтээж байгаа, олон улсын хянан магадлагаа хийгддэг thomson reuters-ийн индекстэй эсвэл scopus-ын индекстэй ийм сэтгүүлд хэр хэмжээний өгүүлэл хэвлүүлсэн юм бэ гэдгээр нь хамгийн гол нь шалгаруулдаг байгаа. Тэгэхээр энэ үзүүлэлтийг хамгийн гол нь энэ хуульд оруулж өгөх ёстой.

Дээрээс нь элсэлтийн бодлогоо бид нар сайжруулах ёстой. Энэ элсэлтийн ерөнхий шалгалтын агуулгыг нь сайжруулах ёстой. Дээрээс нь авдаг, жилд ганц л авч байгаа шүү дээ. Үүнийг нь жилд 3, 4, 5 удаа авдаг. Хүүхэд өөрийгөө бэлдээд сайжруулаад их сургуульд ордог боломжийг нь бид нар олгох ёстой. Мөн ахисан

түвшний элсэлтийн шалгалтыг бас бид нар сайжруулж ингэж бий болгох ёстой. Ахисан түвшин ... /минут дуусав/

**Г.Занданшатар:** Дэмжсэн гишүүд үг хэлж дууслаа. Одоо дэмжээгүй л үг хэлж болно. Норовын Алтанхуяг гишүүн.

**Н.Алтанхуяг:** Би дэмжээгүй ч юу байх вэ дээ. Энэ яриад л явна л даа, хэдүүлээ. Би энэ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйл болбол Монгол Улсын иргэн дараах үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ гээд 18 эрх байдаг юм. Энэ 18 эрхийн 7 дугаарт нь сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй болгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно оо гэж байдаг. Одоо миний санааг маш их зовоож байгаа зүйл бол Монголд бид нар үр хүүхдүүдээ төлбөртэй, төлбөргүй янз бүрийн сургуулиудад багаас нь янз бүрээр нь хуваарилаад, өөрсдийнхөө чадал карман, арга ухаан мэдэхгүй, авлига олон юмаараа ингээд хүүхдүүдийг ер нь замбараагүй болгож байна. Багаас нь ийм тэгш бус өвчинд оруулж байна. Тийм учраас энэ Үндсэн хуулийн энэ заалтыг биелүүлмээр байна.

Ерөнхий боловсролыг бол үнэ төлбөргүй олгох ёстой. Энэ Үндсэн хуулиа л барьж хэдүүлээ юмаа хийх ёстой шүү. Одоо Энх-Амгалан сайд бол тэр дээр бас дөхөө санаатай юм байна гэж би ойлгосон. Тэгээд л одоо орж ирээд л нэг кембриж яриад л, тэгээд нэг дипломатын хүүхэд нь дипломат болдог, ажилчны хүүхэд нь ажилчин болдог, нэг ийм хачин юм руу л явах гээд байна даа. Эртхэн шиг засаж залруулж авъя. Монголын бидний хэнийх нь ч үр хүүхэд ямар ч буруугүй. Тэр хүүхдэд. Тэр хүүхдүүд өөрсдөө яг ижил орчинд тэгш гараан дээр өсөж торниж боловсрох ийм эрхтэй, тэр эрхийг нь эдлүүлье ээ. Би энэ энэ агуулгаараа, энэ хууль бол маш чухал аа гэж ингэж бодож байгаа юм. Би төлбөр ярих гэсэн юм.

Томилгоо гээд нэг юм яриад байна аа даа. Улс төрөөс ангид болгох хэрэгтэй. Энэ бол бас байх ёстой зарчим шүү, чухал зарчим шүү. Хэн нэгэн захирлыг сольдог, өөртөө таалагдсан таалагдаагүй пальдагдсан, пальдагдаагүй юмнууд тавьдгийг болбол таслан зогсоох хэрэгтэй. Энэ тэр хэн нэг намын эрх ашгийг харж болохгүй. Өшөө би нэг жижигхэн юм шиг мөртөө нэг чухал юм хэлчихье.

Сурагчийн дотуур хувцас энэ яамныхан байна. Манай Засгийн газрын үед эхлүүлсэн юм байгаа юм. Үүнийг их жижиг юм гэж хардаг юм. Энэ 30, 40 тэрбум төгрөгийн тийм тулалдаан байдаг юм байна лээ. Тэр тулалдаанд бид нар ялагдаад дууссан. Тэгэхдээ бид биш, Монголын хүүхдүүд, эцэг эхчүүд ялагдсан шүү, та нар мэдэж байна уу, мэдэхгүй байна уу, мэдэхгүй. Одоо энэ хүүхдийнхээ хувцсыг өөрсдөө дотооддоо хийх юм бол асар их хэмжээний ажлын байр маш олон эмэгтэйчүүд аймагт хүүхдүүдийн хувцсыг оёдог ийм юм эхлүүлсэн шүү дээ. Одоо унтарсан байх гэж бодож байна. Яагаад гэхээр үүний мөнгө нь болбол 30, 40 тэрбумын тендер байдаг юм байна лээ шүү дээ. Тийм тэрэн дээр алаан хядаан болоод янз бүрийн юм хийгээд дуусгасан. Энэ чинь шууд хамаагүй мөртөө Энх-Амгалан сайд аа. Бүр тэр байтугай Солонгост нөгөө хүүхдийн хувцасны нөгөө формын хувцасных нь даавууг хийлгэхээр Монгол ямаа, Австралийн ямааны ноолуур, ноос холиод ийм зөндөө юм хийгдсэн шүү дээ. Хайран юм. Одоо тэр зогсчихлоо.

Ингээд хэлэлцэх явцад болбол нэлээн ажлын хэсэгт нь орж идэвхтэй ажиллана аа. Олон хүний санаа оноог сайн шинээр, тэгэхдээ шударга хүүхдүүдэд бүгдэд нь тэгш боломж олгосон ийм л хуулийг бид гаргах ёстой.

**Г.Занданшатар:** Балжиннямын Баярсайхан гишүүн.

**Б.Баярсайхан:** Хуулийн төслийг бол дэмжиж байгаа. Ажлын хэсэгт бас орж ажиллана аа. Би нэг зүйлийг хэлье. Яаманд ажиллаж байхдаа хэдэн багш нарыгаа Солонгос улсад туршлага судлуулахаар явуулсан. Ингээд маш сайн хөгжмийн багшийн хичээлд суусан. Багш нар маань бид нар олуулаа энд ирэхэд зардал их орно оо. Виз авах хэцүү. Тийм учраас та ингээд боломжтой бол Монголд очиж бас ингээд багш нарт хичээл заагаач ээ гэж хэлсэн. Тэр багш юу гэж хэлсэн гэхээр би Солонгос хүүхдийг л яаж бэлтгэхийг мэдэх болохоос биш Монгол хүүхдийг яаж бэлтгэхийг би мэдэхгүй шүү дээ гэсэн байхгүй юу. Тэгээд би үүгээр юу гэж хэлэх гэж байна гэхээр иргэнээ бэлддэг төрийн хүний нөөцийн хар хайрцгийн бодлого гэж бол төрд заавал байх ёстой. Тэгээд энэ болбол өнөөдрийн боловсролын багц хууль бол яг энэ бодлогыг хэрэгжүүлэх ийм хууль юм аа.

Соёлын тухай хууль сая батлагдсан. Энэ дээр бол хүүхдийг зөв хүн болгож төлөвшүүлэхэд Монгол уламжлалт зан заншил, өв соёлоо мэддэг байх ийм иргэн бэлтгэх гэсэн ийм зорилгыг бол бид нар соёлын хуульд тусгуулсан байгаа

Тэгэхээр Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Алсын хараа 2050 үзэл баримтлалд хүний хөгжлийн цогц бодлогыг боловсруулна гэсэн бид нар маш том зорилготой. Тэгэхээр энэ хүний хөгжлийн цогц бодлоготой болоход энэ боловсролын багц хууль бол суурь хууль нь болно оо гэдгийг хэлье ээ.

Тэгээд маш олон асуудал байгаа. Багшийн асуудал, дээд боловсрол, СӨБ-ийн асуудал. ЕБС-ийн асуудал, гэхдээ яг тэр хүүхдийг тэр яг хүн болж төлөвших. Тэр бага насных нь асуудлыг би илүү их чухалчилж яриад байгаа гэдгийг ажлын хэсэг бас анхаараарай.

Масловын онол гээд ядаж 1943 онд нь Америкийн эрдэмтний гаргасан хүний хэрэгцээний суурь онолоо энэ хуульдаа бас яаж тусгах юм. Физиологийн хэрэгцээ нь ямар байх юм, аюулгүй орчинд амьдрах, сурах тэр хэрэгцээг нь яаж хангаж байгаа юм. Хүнд хайрлагдах, хүндлэгдэх тэр хэрэгцээг нь бид нар яаж хангаж байгаа юм. Энэ боловсролын хуулиа сайн хийж энэ суурь хэрэгцээ болсон энэ фундаментаа бид нар одоо цутгах хэрэгтэй гэдгийг энд байгаа мэргэжлийн хүмүүс бол сайн анхаарах хэрэгтэй шүү гэдгийг бол анхааруулж хэлмээр байна. Ингээд энэнээс цааш бид нар сууриа сайн хийчих юм болбол танин мэдэх, хөгжихүй, боловсрох тэр гадаад дотоодод боловсрол эзэмших энэ ген энэ чадвар нь тэртээ тэргүй, одоо Монгол хүүхдүүдэд байдаг аа. Тийм учраас энэ боловсролын багц хууль бол бид нар ямар иргэнтэй байх вэ, ямар улс орон байх вэ гэдгийн суурь хууль юм шүү гэдгийг анхааруулж хэлье ээ. Онцлон хэлье, Тэгээд дэмжиж байна.

**Г.Занданшатар:** Баярлалаа.

Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад бэлтгээрэй. Санал хураалтын төхөөрөмжийг шалгаарай.

Санал хураалтад бэлтгэж байх хооронд энэ чухал хуулийг санал хураалтад гишүүдийн оролцоог хангаж байх хооронд бас 3 үг хэлье ээ.

Сүүлийн 3 жилийн хугацаанд энэ боловсролын реформ, шинэчлэлийн асуудлаар ярилцаж оролцож бид нэлээн их ажилласан, уншиж судалсан. Тэгээд энэ Боловсрол, шинжлэх ухааны сайдаар Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд томилогдоод энэ ажлыг бас их эрчимжүүлж, загварчлалыг гаргаж олон эрдэмтэн судлаачдыг дайчилж, харьцангуй богино хугацаанд харин маш сайн чанартай, том хуулийн төсөл өргөн барьсан гэж итгэж байна. Объем цар хүрээг нь харахаар бол тийм харагдаж байгаа. Маш олон асуудлууд тэгэхдээ дотор нь байгаа учраас бүх нийтээр хэлэлцүүлэх нь зүйтэй.

Тэгээд би нэг ийм зарчмын горимын саналыг бас энэ боловсролын реформыг хэрэгжүүлэхэд онцолж тэмдэглэж хэлье гэж бодож байна аа. Ажлын хэсэг, Боловсрол шинжлэх ухааны яам, Байнгын хороодын гишүүд анхааралтай сонсоно уу. Яагаад гэвэл энд яг энэ ажлын хэсэгт ажиллах гишүүд одоо сууж байна л даа. Сая яг саналаа илэрхийлсэн. Манай Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Ёндонпэрэнлэйн Баатарбилэг гишүүн, Чинбатын Ундрам, гишүүн, Гонгорын Дамдинням гээд гишүүд энэ асуудлаар бас нэлээн ярьсан. Тэгэхээр нэгдүгээрт энэ шинэ хандлага дээр байна шүү дээ, аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал, дижитал зууны энэ эрин үед боловсролыг тэр дотор дээд боловсролыг универсал болгох бүх нийтийн болох чиг хандлага хүчтэй өрнөж байна аа.

Жой Байден ерөнхийлөгч болоод дээд боловсролын эхний 2 жилийг бүх нийтийн боловсрол болгох нь Америкийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ ээ гэж зарласан. Одоо тэр чиглэл рүүгээ хамгийн либерал улс болох Америк явж байна. Европын бараг бүх орнуудын дээд боловсрол үнэ төлбөргүй. Энэ нөгөө дэлхийн өрсөлдөх чадвар, өөрөөр хэлбэл боловсрол дээр тулгуурлаж байгаа дижитал эрин зууны шинэ эрин зууны үе учраас бас нөгөө талаасаа боловсролд маш том дэвшлүүд гарч байгаа. Энэ шинэ боломжуудыг дижитал эрин буюу аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгал рүү хийх гэж байгаа учраас Монгол Улсын дээд боловсролын эхний 2 жилийг бүх нийтийн болгоё оо. 12 жилд шилжихээсээ илүү дээд боловсрол бүх нийтийн болгоё. Тэгвэл дунд сургуулийн ачааллаасаа авахуулаад их, дээд сургуулиудын өрсөлдөх чадвар ч сайжирна. Нөгөө талдаа ерөнхий боловсролын сургуулиудын ачаалал ч бас оновчтой болох. Ер нь дэлхий нийтийн хандлага энэ чиг рүү дэлхийн боловсрол судлалын том эрдэмтдийн шинэ чиг хандлага, энэ тэгш боломж нийгэмд олгох нь ямар чухал вэ гэдгийг Англиас авахуулаад дэлхийн том эрдэмтэд томъёолоод эхэлчихсэн. Тэгээд энэ дээр тулгуурлавал тэр мэргэжлийн боловсролын асуудал ч тэр. Тэгээд тэр академик эрх чөлөө, institutional autonomy 2-ыг нь ингээд өгөх юм болбол манай боловсрол манай залуучууд, багш нар чадалтай. Тэгээд багш нарын цалин хөлс ч гэсэн тэрийгээ дагаад нэмэгддэг. Ийм том хөдөлгүүр болгосон реформыг хийж чадвал энэ бидний, манай Их Хурлын хийсэн том түүхийн реформ болох байх гэж бодож байна.

Тэгээд энэ чиглэлээр манай эрдэмтэн судлаачид ч гэсэн анхаарч, нарийвчлан судалж оролцвол сайн байна аа. Ер нь бид саяын жижиг мөртөө том асуудал гэж Норовын Алтанхуяг гишүүний хэлсэн санал ч гэсэн маш чухал үнэтэй санал юм байгаа юм шүү. Тэр Монгол хонины ноосоороо даавуу хийгээд, түүгээрээ сурагчийн дүрэмт хувцас үйлдвэрлэж байсан. Бас л тендер гээд л нэг бужигнуулаад л байхгүй болгоод л, тэднүүсийг нь дампууруулаад л ингээд орхигдсоноос авахуулаад маш олон ийм жижиг асуудлын дотор бас байгаа. Чөтгөр

детальд нуугдаж байдаг гэж ярьдаг. Тийм учраас энэ бүх чөтгөрүүдийг илрүүлж гаргахын тулд энэ зунжин бас нэлээн эрчимтэй бөгөөд цаг нар завгүй ажиллах ийм шаардлага бидний өмнө тулгарч байна аа.

Ингээд Байнгын хорооны саналаар Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Судалгааны их сургуулийн эрх зүйн байдлын тухай, Боловсролын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Бага, дунд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн зарим хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гамшгаас хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн зарим заалт, хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Монгол улсын батлан хамгаалах тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Ойн тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын өвийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хог хаягдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, Эрүүл ахуйн тухай хуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцох тухай, Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай, төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Санал хураалт.

Бүртгэлийн санал хураалтад 39 гишүүн бүртгэлд орсонгүй гарч байна.

Энэ 39 гишүүнд бүртгэлд ороогүйг мэдэгдэж, санал хураалтад бэлтгэе.

Эхний санал хураалт бол бүртгэлийн санал хураалт байгаа. Энэ систем гацаж байна гэж байна шүү. Бүртгэлийн санал хураалтад системийн гацаа байгааг арилгаарай.

Одоо туршилтын санал хураалт. 21 гишүүн бас туршилтад системийн асуудал байна шүү. Хэлээрэй.

Одоо Байнгын хорооны саналаар хэлэлцэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 65 гишүүн оролцож, 45 гишүүн дэмжиж, 69,2 хувийн саналаар санал дэмжлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороонд шилжүүлж байна.

Байнгын хороо, ажлын хэсгээ байгуулаад. Энэ тулаанд хүчтэй нь үлддэг гэдэг шиг энэ үлдсэн гишүүдээр ингээд ажлын хэсэг байгуулах нь байна шүү.

Тэгээд хууль тус бүрээр тусдаа ажлын хэсэг байгуулаад.

Дараагийн асуудалд орно.